



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

2022 он

МЭНДЧИЛГЭЭ



Монгол улс, бүс орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулан, оюун ухаан хүч хөдөлмөрөө зориулж, үндсэн үүргээ биелүүлсээр ирсэн тус компанийн нийт уурхайчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллага хамт олон та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд хүрч ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хямралыг даван туулж буй энэ цаг үед компанийн гол зорилго болсон дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болох хөгжлийн ирээдүйд чиглэсэн бодлого тодорхойлж боловсронгуй болгон түүнийг хэрэгжүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагаа чиглэж ирлээ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйлдвэрийн шинэчлэл, цаашдын үйл ажиллагааны өрнөлттэй уялдуулан зайлшгүй шаардлагатай байгаа машин техник үндсэн хөрөнгө худалдаж авах, түрээсээр авч ажиллуулах тухай үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудал, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийн тухай, удирдлага зохион байгуулалтын асуудал зэрэг онцгой чухал асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж удирдамжаар хангаж байлаа.

Бидний цаашдын хөгжил дэвшилд хүрэх зорилго, зорилгоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, харилцагч түнш байгууллагууд, уурхайчид нийт хамт олны хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээс шалтгаалан, хүндрэл бэрхшээлийг даван туулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХУЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Шарын гол” Хувьцаат компани нь “Газрын баялгийг гүн боловсруулж, хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, харилцагчийн хэрэгцээг эрхэмлэнэ” гэсэн эрхэм зорилготойгоор Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлага, төлөвлөлт, үндсэн үйлдвэрлэл болон хангалт, үйлчилгээний бүтцийн нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

- ❖ **Нэр:** “Шарын гол” ХК
- ❖ **Үндсэн харьяалал:** Монгол улс
- ❖ **Хаяг:** Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг Санжинт
- ❖ **Утас:** 7037-2235
- ❖ **Факс:** 7037-2235
- ❖ Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.
- ❖ **Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 1910010009
- ❖ **Регистрийн дугаар:** 2050374
- ❖ Тус компани нь Монгол улсын хойд бүсийн Дулааны цахилгаан станцууд болон Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр бусад хэрэглэгчид болох Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий байгууллагуудын үйл ажиллагааг нүүрсээр тасралтгүй ханган ажилладаг онцгой объектуудын нэг юм.
- ❖ **Компанийн эрх барих дээд байгууллага:** Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана

Монгол улсын ууган уурхайнуудын нэг болж, Төвийн болон Хойд бүс нутгийн байгууллага, аж ахуй нэгж болон иргэд хөдөлмөрчдийнхөө гал голомтод бадран асах нүүрс хэмээх “хар алт”-ыг тасралтгүй ханган нийлүүлж, түүхэн замналаа бичиж ирсэн “Шарын гол” ХК нь өдгөө 57 дахь жилдээ амжилттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2, 3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 28-ний өдрийн 13⁰⁰ цагаас Чингэлтэй дүүргийн 3-р хороо, Жуулчны гудамж Пиэрл Тауэр В корпус 9 давхар 1 тоотод хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - а) Компанийн 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
 - б) Компанийн ТУЗ-ийн 2022 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
 - в) Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл.
3. Хурал хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдрийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр байхаар тогтоосугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудасны загварыг хавсралт 1-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон, танилцах бичиг баримтын жагсаалтыг хавсралт 2-оор, хэвлэл мэдээллээр зарлах хурлын зарыг хавсралт 3-аар, тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал /Б.Мэндсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Л.Эрдэнэжаргал/ нарт даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар, ТУЗ-ийн дарга Г.Хуланг томилсугай.
8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд: Комиссын дарга: – ТУЗ-ийн дарга Г.Хулан
Комиссын гишүүн: - Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан
-Ө.Энхтайван - ТУЗ-ийн н/б дарга
9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.
Комиссын дарга: – Г.Өүлэн – Хангамжийн мэргэжилтэн
Г.Энх-Эрдэнэ –Захирлын туслал
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг, хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны графикыг мөрдлөг болгон зохих хууль журмын дагуу хуралдуулахыг комисс /Г.Хулан/-д үүрэг болгосугай.



2021 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Шарын гол” ХК нь 2021 онд 6 хэлтэс, 6 хэсэг, 1 алба, 1 сургалтын төв гэсэн бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр, нийт хамт олноороо стратеги төлөвлөгөө, зорилго зорилтдоо хүрэх эрхэм үүргийг өмнөө тавин, ажил үүргээ гүйцэтгэн ажилласан.

2021оны 01 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөнөөс гадуур нэмэлтээр хийгдсэн ажил, хэлтэс хэсгийн ажилтнуудын ажил үүргийн байдал, санал дүгнэлтийг дараах тайлангаар нэгтгэн танилцуулж байна.

“Шарын гол” ХК-ийн 2021 оны хэлтэс, хэсгийн үйл ажиллагааны тайлангийн бүтэц:

1. Технологи бодлогын хэлтэс
2. Лабораторийн хэсэг
3. Уулын үйлдвэрийн хэлтэс
4. Нүүрс ангилан ачих хэсэг
5. Төмөр замын хэсэг
6. Механик засварын хэсэг
7. Цахилгаан шугам сүлжээ хэсэг
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналтын хэлтэс
9. Санхүү төлөвлөлтийн хэлтэс
10. Борлуулалтын алба
11. Худалдаа хангамжийн хэлтэс
12. Захиргаа хүний нөөцийн хэлтэс
13. Сургалтын төв
14. Аж ахуйн хэсэг
15. Компанийн засаглал, Төлөөлөн удирдах зөвлөл

НЭГ: ТЕХНОЛОГИ БОДЛОГЫН ХЭЛТЭС

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

- **Уулын ажлын төлөвлөлт:** 2021 оны уулын ажлын төлөвлөгөөг Pushback-Grave Yard /ext/, ба Зүүн жигүүр, Шаазгайт гэсэн 3 үндсэн хэсэгт уулын ажлыг явуулахаар төлөвлөн ажилласан.
- 2021.01-2021.12 дугаар сар хүртэл нийт 8954.84 мян.м³ хөрс хуулахаас 6243.37 мян.м³ хөрс хуулж **70% гүйцэтгэлтэй**, нүүрс олборлолт 1124.3 мян.тн олборлохоос 1159.1 мян.тн олборлож **103%-н гүйцэтгэлтэй** ажилласан. Орд тус бүрээр нь доорх хүснэгт болон графикаар харуулав.

Хүснэгт 1

д/д	Үзүүлэлт	Х/нэгж	2021.01.01-2021.12.31		Биелэлт
			Төл	Гүйц	
1	Нийт нүүрс олборлолт	мян.тн	1,124.3	1,159.1	103%
	Зүүн жигүүр	мян.тн	485.71	173.39	36%
	РВ	мян.тн	492.57	806.75	164%
	Geave yard ext	мян.тн	146	178.32	122%
	Нөөцөөс	мян.тн		0.61	
2	Нийт хөрс хуулалт	мян.м3	8,954.84	6,243.37	70%
	Зүүн жигүүр	мян.м3	2,054.46	1,094.35	53%
	РВ	мян.м3	3,918.64	4,012.53	102%
	Geave yard ext	мян.м3	1,217.08	1,050.65	86%
	Шаазгайт	мян.м3	1,764.66	73.79	4%
	Бусад ажил	мян.м3		12.05	
3	Нийт уулын цул	мян.м3	9,819.67	7,134.9	73%
4	Шидэлт	мян.м3	0	299.2	
5	Өрөмдлөг	м	34118	29046	85%
6	Тэсэлгээ	мян.м3	1,359.40	1,159.8	85%
	Үүнээс-анфо	мян.тн	141.1	93.95	67%
	эмульс	мян.тн	142.4	120.7	85%
7	Хөрс хуулалтын коэффициент	м3/тн	7.96	5.39	68%

График 1

Хөрс хуулалтын гүйцэтгэл:





График 2

Нүүрс олборлолтын гүйцэтгэл:



З
У
У
н

- Зүүн жигүүрийн ордын төлөвлөлт: 2021.01-2021.12 сар хүртэлх уулын ажлын төлөвлөгөөгөөр 2054.46 мян.м3 хөрс хуулахаас 1094.35 мян.м3 хөрс хуулж 53%-тай, нүүрс олборлолтын ажил төлөвлөгөөгөөр 485.71 мян.тн олборлохоос 173.39 мян.м3 олборлож 36%-н тус тус гүйцэтгэлтэй байна. Доорх графикт үзүүлэв.

З
У
н

Зүүн жигүүрийн жилийн эхнээс хөрс хуулалт болон нүүрс олборлолт:

График 3

2021.01.01-2021.12.31 хөрс хуулалт, мян.м3





График 4

2021.01.01-2021.12.31 нүүрс олборлолт, мян.тн




- Зүүн жигүүрийн орд газарт хөрс хуулалтад ажиллахаар төлөвлөсөн гидроэкскаваторын гэнэтийн эвдрэл гэмтэл сэлбэг хангамж, уул геологийн хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалан хөрс хуулалтын ажил хоцрогдож дагаад нүүрс олборлолт борлуулалтын ажил төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.

Шаазгайтын орд:

- **Шаазгайтын ордын төлөвлөлт:** 2021.01-2021.06 сар хүртэлх уулын ажлын төлөвлөгөөгөөр хөрс хуулалт 1764 мян.м³ хөрс хуулахаас 73.79 мян.м³ хөрс хуулж 4% гүйцэтгэлтэй ажилласан. Шаазгайтын ордын хөрс хуулалтын ажил ТЭЗҮ батлагдаагүйн улмаас уулын ажлыг уурхайн удирдлагын шийдвэрээр зогсоосон.

Зураг 1



ҮНДСЭН ОРД:

- **Үндсэн ордын төлөвлөлт:** 2021.01-2021.12 сар хүртэлх уулын ажлын төлөвлөгөөг North high wall, Үндсэн болон Grave yard EХТ хэсгүүдээс ашиглалтын блокуудад хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг төлөвлөсөн.
- **Үндсэн ордын гүйцэтгэл:** 2021.01-2021.12 сар хүртэл Grave yard EХТ ашиглалтын блокт 146.0 мян.тн нүүрс олборлохоос 178.32 мян.тн нүүрс олборлож 122%-н гүйцэтгэлтэй, хөрс хуулалт 1217.08 мян.м³ хөрс хуулахаас 1050.65 мян.м³ хөрс хуулж 86%-н гүйцэтгэлтэй ажилласан.
- North high wall ашиглалтын блокт 492.57 мян.тн олборлохоос 806.75 мян.тн олборлож 164%- гүйцэтгэж хөрс хуулалт 3918.64 мян.м³ төлөвлөснөөс 4012.53 мян.м³ хөрс хуулж 102%-н гүйцэтгэлтэй тус тус ажилласан. Нүүрс олборлолтыг төлөвлөсөн хэмжээнээс 64% илүү олборлосон нь Зүүн жигүүрийн ордын хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил хоцрогдсоноос шалтгаалан олборлолтыг хийсэн.

График 5





График 6



Grave yard EXT:

График 7





График 8



ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ

34,118 тууш метр өрөмдөх төлөвлөгөөтэй ажилласнаас 29,046 тууш метр өрөмдөж 85% гүйцэтгэлтэй ба 4275 цооног өрөмдсөн ба цооногуудын төрлөөс харвал 1-20 м гүнтэй цооног өрөмдсөнөөс хамгийн их 2 м-тэй 1058 цооног өрөмдсөн байна.

Тэслэгдэх уулын цулын 90%-г North high wall хэсгээс 830-р түвшингөөс доош тэсэлгээний ажил гүйцэтгэхээр, үлдсэн 10%-н Grave yard хэсэгт байх ба тэсрэх бодисын зарцуулалтын 0.25м³/тн байхаар төлөвлөсөн. Уулын ажлын геологийн нөхцөл дараалал техник зохион байгуулалтаас шалтгаалж өрөмдлөг, тэсэлгээний ажил багассан. Үүнээс төлөвлөснөөр тэслэгдэх уулын цул 1359.0 мян.м³ хөрс тэслэхээс 1159.853 мян.м³ уулын цул тэсэлж 85% гүйцэтгэлтэй ажилласан. Уулын ажлын дараалал техник зохион байгуулалтаас болон ковид-19 өвчний улмаас шалтгаалж өрөмдлөг, тэсэлгээний ажил тэслэх уулын цулын ажлууд хойшлогдон үлдсэн байгаа.

Хүснэгт 2

Тэслэгдсэн уулын цулын гүйцэтгэл:

Сар	Тэслэх уулын цулын төлөвлөгөө. мян.м ³	Тэсэлсэн уулын цулын гүйцэтгэл мян.м ³	Тэсрэх бодисын төлөвлөгөө	Анфо /тн/			Эмульс /тн/		
				төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	зөрүү
коэф									
1	735.205	250,638.0	173.8	75.2	20.90	(54.26)	98.69	30.34	(68.34)
2	205.234	398,681.0	47.0	24.1	46.60	22.52	22.97	49.61	26.64
3	83.689	24,237.0	18.6	17.6	0.00	(17.57)	1.05	4.08	3.03
4		12,600.0	-	-	0.00	0.00	-	1.20	1.20
5		85,070.0	-	-	2.65	2.65	-	4.25	4.25
6		-	-	-	0.00	0.00	-	0.00	0.00
7		-	-	-	0.00	0.00	-	0.00	0.00

8	90.000	151,800.0	22.500	9.000	11.13	2.13	13.500	16.01	2.51
9	105.207	-	6.312	3.787	0.00	(3.79)	2.525	0.00	(2.52)
10		124,191.0	-		3.83	3.83		12.26	12.26
11	120.020	48,000.0	7.201	4.321	3.25	(1.07)	2.880	0.48	(2.40)
12	20.000	64,636.0	8.000	7.200	5.60	(1.60)	0.800	2.51	1.71
Нийт	1,359	1,159,853	283.5	141	93.95	(47)	142	120.744	(22)


ТЭСРЭХ БОДИС

Тэсэлгээний ажлыг Grave yard EXT, North high wall хэсгүүдэд хийхэд 214.69 тн тэсрэх бодис хэрэглэгдсэн. Үүнээс анфо 93.95тн, эмульс 120.74 тн. 56:44-н харьцаатай байна. Зүүн жигүүрийн орд хэсэгт уулын геологийн нөхцөл хүндрэлтэй уурхайд орж ирэх шүүрлийн ус ихтэй, өрөмдсөн цооног устай зэргээс шалтгаалан эмульсийн тэсрэх бодисын хэрэглээ нэмэгдсэн.

Тэсэлгээний ажлын зарцуулалт, өртөг:

- 2021.01-2021.12 сарын байдлаар тэсэлгээний ажлын өртөг 427.38 м³/төг, зарцуулалт 0.11кг/м³ байна.

График 9




Хүснэгт 3

	Тэсэлгээний өртөг, төг/м³	Тэсрэх бодисын зарцуулалт, кг/м³	Уулын цул.мянм³
1	581.18	0.20	250,638.00
2	753.37	0.24	398,681.00
3	976.85	0.17	24,237.00
4	871.71	0.10	12,600.00
5	246.17	0.08	85,070.00
6	-	0.00	-
7	-	0.00	-
8	507.51	0.18	151,800.00

9	-	-	-
10	493.09	0.13	124,191.00
11	191.651	0.08	48,000.00
12	507.02	0.13	64,636.00
Дундаж	427.38	0.11	1,159,853.00

График 10




ХОЁР: НҮҮРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ХЭСЭГ

- ❖ Бүтэн жилийн төлөвлөсөн ажлын тоо: 18
- ❖ Биелсэн ажлын тоо: 18
- ❖ Гүйцэтгэл: 100%
 - Уурхайн нөөцийн талбайнуудын нүүрсний дээжийн шинжилгээг 5, 10, 15, 20, 25, 30 байдлаар хийж шинжлэх, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй дээж авч, шинжлэн сорилтын тайлан гаргах. Энэ ажлын хүрээнд 2021 оны байдлаар мөргөцгөөс нийт 252 удаагийн дээж авч, шинжлэн сорилтын тайлан гаргасан байна.
 - Борлуулалтын төлөвлөгөөний дагуу станцуудад ачигдсан нүүрснээс дээж авч, шинжилгээ хийж, сорилтын тайлан гаргах. Мөргөцгийн шинжилгээний дүнд үндэслэн холилтын төлөвлөгөөг гаргаж, станцуудыг гэрээнд заагдсан илчлэгтэй нүүрсээр ханган ажилласан.


Дархан ДЦС, Эрдэнэт ДЦС, УБЭҮ-ийн шинжилгээний дүн: 1-р хагас жилээр

График 11



Дархан ДЦС, Эрдэнэт ДЦС, УБЭҮ-ийн шинжилгээний дүн: 2-р хагас жилээр


График 12



Цооногийн /Govisaravan/ дээжид шинжилгээ хийж, сорилтын тайлан гаргах: Говь караваны 1481 дээжид шинжилгээ хийж, сорилтын тайлан гаргасан.


1-р Хагас жилд шинжилгээ хийсэн нүүрсний дээжийн тоо:

График 13



2-р Хагас жилд шинжилгээ хийсэн нүүрсний дээжийн тоо:

График 14



- **Ур чадварын сорилтын 9-р тойрогт оролцох:** 2021 оны 06 сард ГТЛ-аас зохион байгуулсан УЧС-ын 9-р тойрогт амжилттай оролцож, хангалттай үнэлгээгээр үнэлэгдэн сертификат авсан.
- **Сар бүр өөрийн дээжид дотоод хяналт хийх:** Лабораторийн дотоод харьцуулалт хийх зорилгоор 19 удаагийн дээжид шинжилгээ хийж, дотоод хяналт явуулав.
- **Гадаад хяналт хийх:** Дархан ДЦС болон Эрдэнэт үйлдвэрийн нүүрсний шинжилгээний лабораториудтай дээж солилцон шинжилгээ хийв. Шинжилгээний үр дүн 2 лабораторийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна.
- **Дизель түлшний шинжилгээ хийх:** “Шарын гол” ХК нь “Собу петро” ХХК-аас дизель түлшийг авч хэрэглэдэг. Түлшний лаборатори 6 сард ашиглалтад орсон 43 удаагийн түлшний дээж авч, шинжилгээ хийж, munkhbat@sharyngol.mn; todbayar@sharyngol.mn; ganerdene@sharyngol.mn, bayrmagnai@sharyngol.mn, uyanga@sharyngol.mn, ganzorig@sharyngol.mn, batbold@sharyngol.mn нарт шинжилгээний дүнг тухай бүрт нь илгээсэн. Сорилтын тайлангаа “НИК” ХХК-ийн лаборантад танилцуулан зөвлөгөө авсан. 3 удаагийн дээжид хийсэн сорилтын дүнгээр тухайн түлш стандартын шаардлага хангасан байна. 2021 оны 7-12 сарын хугацаанд дизель түлшний 43 дээжид шинжилгээ хийж, сорилтын тайлан гаргасан.
- **Лабораторийн багаж, хэрэгслийн шалгалт тохируулгыг хуваарийн дагуу хийх:** Лабораторийн багаж, хэрэгслийн шалгалт тохируулгыг хуваарийн дагуу хийх. Лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын төлөвлөгөө гаргаж, 7 сард калориметр-1, аналитик жин-3, техник жин-1 багажид Стандарт хэмжилзүйн газраар шалгалт тохируулга хийлгэсэн.
- **Баримт бичгийн хөтлөлтийг тогтмол хийх, сайжруулах:** Чанарын гарын авлага, стандарт ажлын заавар, тоног төхөөрөмж ашиглалтын заавар, техникийн паспортууд, ХАБЭА бичиг баримтын хөтлөлтийг тогтмол хийж, түлшний шинжилгээний журам, САЗ, тоног төхөөрөмж ашиглалтын заавар, техникийн паспортууд, түлшний шинжилгээний АА-ны зааврыг шинээр боловсруулан хөтлөлт хийж байна.

- **Шинжилгээний стандарт ажлын зааврыг шинэчлэх, шинээр боловсруулах:** Нүүрсний шинжилгээний 5 стандарт ажлын зааврыг /чийг, үнс, дэгдэмхий, хүхэр, илчлэг/ шинэчлэн, түлшний шинжилгээний 7 стандарт ажлын заавар /хувийн жин тодорхойлох, дөл үүсэх температур тодорхойлох, найрлагын бүрэлдэхүүн тодорхойлох, зууралдах чанар тодорхойлох, царцах булингартах температур тодорхойлох, шүүгдэх температур тодорхойлох, цетаны тоо тодорхойлох/ шинээр боловсруулсан.
- **Техник ашиглалтын паспортуудыг шинэчлэх, шинээр боловсруулах:** Нүүрсний шинжилгээний лабораторийн 12ш техник ашиглалтын паспортыг шинэчилж, түлшний лабораторийн 7ш техник ашиглалтын паспортыг шинээр хийсэн.
- **Лабораторийн барилга байгууламж тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх:** Лабораторийн өрөөний засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн 2021-2022 оны төсөвтөө тусгасан. Алхан бутлуурыг техникийн комиссын хурлаар оруулж актлуулах шийдвэр гарсан.
- **Лабораторийн ажилчдыг сургалтад хамруулах:** “Грийн Химистри” ХХК-с зохион байгуулсан “Нүүрсний хүхрийн агуулгыг тодорхойлох арга SDS350” онлайн сургалтад лабораторийн эрхлэгч хамрагдсан. ЧБББА-с зохион байгуулсан “Процессын зураглал хийх аргачлал” сургалтад лабораторийн эрхлэгч хамрагдсан. “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ”-ий 40 цагийн онол дадлагын сургалтад лабораторийн эрхлэгч, лаборант-1 хамрагдан гэрчилгээ авсан. Итгэмжлэлийн үндэсний төсөөс зохион байгуулсан “MNS ISO 17025:2018” стандартын сургалтад дээж авагч-2, лабораторийн эрхлэгч-1 нийт 3 ажилтан хамрагдан сертификат авсан. “Шарын гол” ХК-ийн дотоод сургалтад ажилчдаа хамруулсан. Нийт 10 удаагийн сургалтад хамрагдсан. Ирц: 60%
- **ХАБЭА-н ажилд санаачлагатай оролцох:** ХАБЭА 1-6 сарын ажлын төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг гаргаж ажилласан.
- **Давтан итгэмжлэлийн үнэлгээнд орох:** 10 сарын 13, 14 өдрүүдэд Монголын итгэмжлэлийн төвөөс манай лаборатори дээр итгэмжлэлийн үнэлгээ хийсэн. 4 үл тохирол, 8 зөвлөмж өгснийг 1 сарын хугацаанд төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу залруулж, итгэмжлэлээ 4 жилээр сунгуулсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан хийгдээгүй ажлууд, шалтгаан нөхцөл


- **Лабораторийн нүүлгэн шилжүүлэх ажил:** Лабораторийн нүүлгэн шилжүүлэх ажлын зураг, барилга, сантехник, цахилгааны төсөв гарч батлагдан дараа онд хийгдэхээр шийдвэрлэгдлээ.

ГУРАВ: УУЛЫН ҮЙЛДВЭРИЙН ХЭЛТЭС

Нэг. Хөрс хуулалтын төлөвлөгөө гүйцэтгэл /сараар/

- Нийт хөрс хуулалт нь 84% гүйцэтгэлтэй ажилласан байна.


График 15



Хоёр. Нүүрс олборлолт төлөвлөгөө гүйцэтгэл /сараар/

- Нийт нүүрс олборлолт нь 109% гүйцэтгэлтэй ажилласан

График 16



Гурав. Нийт техник цаг ашиглалт, техникийн бэлэн байдал

График 17





График 18



Дөрөв. Түлш зарцуулалт техник тус бүрээр

- ХЕМС дампын түлш зарцуулалт

Хүснэгт 4

Д/д	Хитачи	Нийт түлш	Нийт уулын цул /м3/	м3/литр
1	ХЕМС №226	277,833	1,084,927	0.25
2	ХЕМС №227	286,972	1,073,750	0.26
3	ХЕМС №228	272,520	1,032,878	0.26
4	ХЕМС №229	278,209	964,807	0.28
Дүн:		1,115,534	4,156,362	0.26

- Коматцу дампын түлш зарцуулалт

Хүснэгт 5

Д/д	Комацу	Нийт түлш	Нийт уулын цул /м3/	м3/литр
1	HD465 №37	230359	297834	0.59
2	HD465 №38	107928	269685	0.57
3	HD465 №39	113294	84,662	0.49
4	HD465 №40	145624	293392	0.53
6	HD465 №43			
7	HD465 №44			
Дүн:		152,544	282,306	0.55

- Хово дампын түлш зарцуулалт:

Хүснэгт 6

Д/д	Хитачи	Нийт түлш	Нийт уулын цул /м3/	м3/литр
1	Хово 371 №70			
2	Хово 371 №71	52068	214344	0.24
3	Хово 371 №72	68529	279310	0.24
4	Хово 371 №73	72577	278358	0.26
5	Хово 371 №74	54437	199151	0.27
6	Хово 371 №75	45406	200353	0.22
7	Хово 371 №76	49089	217498	0.22
8	Хово 371 №77	35898	132939	0.27
Дүн:		377,644	1,521,953	0.24

- 2021.01 сараас нүүрс олборлолт graveyard ЕХТ 163.0 мян.тн олборлохоос, 178.83 мян.тн нүүрс олборлож 110%-н гүйцэтгэлтэй, graveyard ЕХТ хөрс хуулалт 597.10 мян.м3 хөрс хуулахаас, 488.97 мян.м3 хөрс хуулж 82%-н гүйцэтгэлтэй ажиллаж, Graveyard ЕХТ дээр уулын ажил явуулж дуусгасан.

Зураг 2



- Газрын гүнд ЦНС 300/240 насос тасралтгүй ажиллаж байна засвар үйлчилгээг тогтмол хийж 2021.01.01-ний өдрийн байдлаар нийт 2866 цаг ажиллаж 8074250 м3 ус соруулж гадагшлуулсан.

Зураг 3



- Зүүн жигүүрийн орд ашиглах болсонтой холбогдуулан ГРТ 160/71 насос, Д1250/51 насос тус тус байрлуулсан.
- 2021.02.23-наас ГРТ160/71 насосоор 190000 м3, Д 1250/51 насосоор 450000 м3 ус зайлуулж ажилласан.

Зураг 4



Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

- Шаазгайтын ордын хөрс хуулалтын ажлыг эхлүүлэх, техник зохион байгуулалтын бэлтгэл ажил хийх

Хүснэгт 7

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Гүйцэтгэлийн хувь /тайлбар/
1	Экскаватор нүүх талбай трасс бэлтгэх	12 хоног	100%
2	Цахилгаан дамжуулах агаарын шугамын трасс хийх	7 хоног	100%
3	Гүүрний хоёр талд шон хийх алсаас орох зам талбай хийж өгөх	5 хоног	100%
4	Байнгын авто замын трасс хучилт хийх	7 хоног	0% тэвэрлэлт болон хөрс хуулалт яваагүй тул
5	Засварын талбай ажилчдын түр байрны талбай хийж хучилт хийх	5 хоног	50% талбай тэгшлэх ажил хийсэн.
6	Ажилчдын наряд өгөх болон хоолонд орох түр байр бэлтгэх	17 хоног	30% талбай тэгшлэх ажил хийсэн.

- Зүүн жигүүрийн уулын ашиглалт эхлүүлэх техник зохион байгуулалтын бэлтгэл ажил

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Гүйцэтгэлийн хувь /тайлбар/
1	Хөрс тээвэрлэх зам бэлэн болгох	12 хоног	100%
2	Нүүрс тээврийн замын трасс хийх	20 хоног	100%
3	Нүүрс нөөцлөх талбай бэлтгэх	15 хоног	100%
4	Ус зайлуулах суваг шуудуу татах	7 хоног	100% одоо ээлж бүр сайжруулалт хийж байна.
5	Алтны олборлолт хийсэн талбайгаар замын далан хийх	7 хоног	100% тээвэрлэлт явж байна.
6	Нүүрс тээвэрлэх замын хучилт хийх	13 хоног	100%

- Шаазгайт орд руу цахилгаан экскаватор-51, экскаватор-38 нүүлгэх ажлыг амжилттай зохион байгуулан нүүлгэж дууссан.

Зураг 5



- Шаазгайтын ордоос экскаватор 1900, экскаватор 8и техникуудийг амжилттай нүүлгэж үндсэн мөргөцөгт ажиллуулсан.

Зураг 6

Экскаватор 1900 нүүлгэх ажлын явц



Экскаватор 8и нүүлгэх ажлын явц



- Манай уурхайн хамгийн өндөр бүтээлтэй цахилгаан экскаватор болох ex-1900 техник дээр амжилт гаргасан оператор нар:

Хүснэгт 9

№	Оператор	EX 51	Нийт хөрс
1	Сүхянжин Сүхбаатар (хөрс)	588609м3	588609м3
2	Сайнбилэг Зургаадай (хөрс)	579261м3	579261м3

- ХЕМС дамп дээр амжилт бүтээлээрээ хамт олноо хошуучлан ажилласан оператор нар:

Хүснэгт 10

№	Оператор	ХЕМС дамп	Нийт хөрс
1	Энэбиш Батөлзий (хөрс)	182540м3	182540м3
2	Төмөрбаатар Аззаяа (хөрс)	180751м3	180751м3

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- Цар тахлын эрсдэлтэй хүнд үед хэсгийн ажилчдыг уурхайн бүсэд байрлуулж үндсэн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд нь зохион байгуулж ажилласан.

Зураг 7



ДӨРӨВ: НҮҮРС АНГИЛАН АЧИХ ХЭСЭГ

2021 онд НААХ нь хөдөлмөрийн бүтээмж, үйлдвэрлэлийн бүтээлийг нэмэгдүүлэх хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

Үндсэн чиг үүрэг:

- Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, компанийн дотоод журмын хүрээнд компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй жигд явуулах, төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд шаардлагатай хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай нүүрсийг буталж, ангилах, ачих, тээвэрлэх, стандартын дагуу шинжилгээг хийж борлуулалтын үйл ажиллагааг хариуцна.

Зорилго:

- Компанийн нүүрс борлуулалтын зорилтот үйл ажиллагааны үндсэн хэсэг болох вагонд нүүрс ачих, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, техникийн засвар үйлчилгээ, бэлэн байдал, найдвартай ажиллагааг хариуцан, хэрэглэгчийн хэрэгцээний дагуу нүүрсийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтмол үр дүн гарган хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэн ангилан ачих ажиллагааг тасралтгүй, аюулгүй явуулах ажлыг оновчтой зохион байгуулах.

Зорилт:

- 2021 онд Үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг сайжруулж, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг боловсруулан, борлуулалтын орлого нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажилласан.

Удирдлага зохион байгуулалт

- Хэсгийн ажлыг хэвийн явуулахын тулд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, тушаал шийдвэрийг тухай бүр нь танилцуулж гүйцэтгэлийг дүгнүүлж ажиллаж ирсэн ба сар бүрийн 1-ний өдөр хэсгийн ИТА нарын зөвлөгөөн хийж ажилчдын наряд болон хэсгийн хэмжээний бүх ажлаа хэлэлцэж дараа сарын ажлаа төлөвлөж ололт амжилт, алдаа дутагдлаа дүгнэж ажилласан.
- Ажлын байрны үзлэг, үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хийж, гарсан зогсолт сааталд шуурхай арга хэмжээ авч ирсэн сэлбэг материалыг тухай бүр нь тавьж хэвийн ажиллагааг хангаж ирсэн.
- Нүүрс борлуулалтын төлөвлөгөөнөөс хамаарч вагон ачилтыг 17-22 цагийн хооронд болон хөнгөлөлттэй үнэ буюу 22-06 цагийн хооронд шөнөөр ачих ажлыг зохион байгуулж ажилласан.

ХАБЭА

- Сар ба өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг цаг хугацаанд нь өгч байсан
- Ажлын байрны тойрох үзлэгийг тогтмол хийж илэрсэн зөрчлүүдийг тухай бүр нь арилгаж ирсэн.
- Аюулыг мэдээлэх хуудсаар ирсэн зөрчлүүдийг арилгаж ирсэн.
- Нийт ажилчдад ХХА, сургалтын албанаас ирсэн safety share танилцуулж баталгаажуулан гарын үсэг зуруулсан.

- Нийт ажилчдын ХХ-ын хувцас, хамгаалах хэрэгслийг ирсэн тухай бүр нь авч өгч түүний ашиглалтанд нь тогтмол хяналт тавьж ажиллаж ирсэн.
- ХХА аас ирүүлсэн албан шаардлагын зөрчлүүдийг тухай бүр нь арилгаж байсан
- ХАБ хэлтэстэй хамтарч "Эргэх механизмын хаалт, хамгаалалт, аюулгүй ажиллагаа" сарын аян зохион байгуулсан.
- Хэсгийн эргэлдэх тоног төхөөрөмжүүдэд хаалт хашилтны судалгаа гаргаж хаалт хашилт тэмдэг тэмдэглэгээ хийж өгсөн.
- ХАБЭА-н холбогдолтой хавтас, бичиг баримтуудыг цаг хугацаанд бүртгэл бичилт хийж явсан.
- 2021 оны ХАБ-н жилийн дүнгээр шагналт 2 байр эзэлсэн.

Техник тоног төхөөрөмж

- Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг, тослогоо, үйлчилгээг тогтмол хийж шаардлага хангахгүйг нь тухай бүрд нь сольж эвдэрсэн зүйлүүдийг засварлан, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна
- Сар болгоны сүүлийн 2 хоног буюу вагон ачилтгүй өдрийг төлөвлөгөөт засварын өдөр болгон ажиллаж байгаа.
- Ээлжийн мастерууд болон засварчид тойрох үзлэгийн хуудас бөглөж эвдрэл гэмтэлд шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна.
- РП дийг 7 хоног бүр үзлэг үйлчилгээ хийлгэснээр цахилгааны саатал гарах нь эрс багассан.
- Ачаалал багатай сар зуны улиралд шөнөөр вагон ачиж засвар үйлчилгээг өдрийн цагаар болон 17-22 цагийн хооронд хийж гүйцэтгэж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.
- Ажлын байрны эмх цэгц цэвэрлэгээ үйлчилгээг байнга хангаж ирсэн.

2021 оны нүүрс борлуулалтын мэдээ

- Сар бүрийн борлуулалтын төлөвлөгөөг биелүүлж ажилласан.
- Нүүрсний чанарт анхаарч УҮХ болон БА-тай уялдаа холбоотой ажилласан.
- Зүүн жигүүрийн нүүрс чийгтэй чанар муутай илчлэг хүрэхгүй байсанг ТБХ-тэй хамтарч холилтын төлөвлөгөөний дагуу ачилт хийсэн.

Хүснэгт 11

№	Худалдан авагч	Х/н	Төлөвлөгөө тонн	Гүйцэтгэл %	Нийт Төгрөг	Нийт %		
1	Цахилгаан станц	тн	1,075,260	1,036,484	96%	47,849,070	47,087,620	98%
	Дархан ДЦС	тн	305,000	302,564	99%	13,572,500	13,501,788	99%
	Эрдэнэт ДЦС	тн	360,000	351,904	98%	16,020,000	15,842,957	99%
	Эрдэнэт үйлдвэр	тн	396,500	368,581	93%	17,644,250	17,130,548	97%
	Дулаан ШГ	тн	13,760	13,435	98%	612,320	597,874	98%
	Сэлэнгэ энерго	тн	-	-	-	-	14,454	-
	Томоохон хэрэглэгч	тн	33,997	50,044	147%	1,894,738	2,813,748	149%
2	УБТЗ	тн	14,725	16,749	114%	854,050	1,001,109	117%
	Ачит ихт	тн	19,272	15,192	79%	1,040,688	815,055	78%
	Цээл буян	тн		14,753			796,674	

	Галдастай	тн		3,349			200,910	
3	Жижиглэн хэрэглэгч	тн	50,800	68,049	134%	3,009,500	4,064,736	135%
	Жижиг компаниуд	тн	31,300	46,620	149%	1,755,000	2,689,239	153%
	Шарын жижиглэн гол	тн	18,500	20,868	113%	1,202,500	1,352,482	112%
	Ажилчид	тн	1,000	561	56%	52,000	23,015	44%
4	Нийт борлуулалт нүүрс	тн	1,160,057	1,154,576	99.5%	52,753,308	53,966,104	102%

2021 онд дамжлагад хийгдсэн ажил

- Эрдэнэт үйлдвэрт туслах хүрдний втулка хийлгэж тавьсан.
- 29-р замын нүүрс нэмэх болон ачилтын талбайг шинээр засаж сайжруулсан
- Булт бутлуурын хөдөлгүүрийг Эрдэнэт үйлдвэрт засуулсан.
- Ачилтын 2 конвейерт шинээр тавьсан 2 жинд тохиргоо хийлгэсэн.
- Жилийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- “Шарын гол” ХК-ийн анхны экспортыг 8 сараас эхэлж 18000 тонн экспортод нүүрс гаргасан. Тогтмол экспортод нүүрс гаргасан
- НААХ-н ачилтын талбай болон шигших хэсгийн талбайн дээврийг хар плёнк дэвсэж шар шавраар хучих ажил хийж дуусгасан
- Хэсгийн амрах байрнуудын цахилгаан монтажийг шинэчилсэн.
- Хэсгийн 3 ажилтан ТЗХ-с зохион байгуулсан сургалтад хамруулсан.
- Ковидын нөхцөл байдлын улмаас уурхай дээр графикаар байрлаж ажилласан.

ТАВ: ТӨМӨР ЗАМЫН ХЭСЭГ

2021 оны жилийн төлөвлөсөн ажлын тоо: Төмөр замын хэсгийн ИТ 7385 нь нүүрсний сэлгээ болон аж ахуйн сэлгээ хийх 1,086,528 тонн нүүрс 16463 вагонд сэлгээ хийх, зам засварын ажилд сар бүр төлөвлөгөө гарган хагас жилийн хугацаанд 134 ажил төлөвлөсөн.

Гүйцэтгэл: /хувиар/ 2021 онд 99,3%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

Бүх зам, суманд хийгдсэн ажил:

Хүснэгт 12

№	Хийгдсэн ажил	Хэмжих нэгж	Нийт дүн
1	Цариг тохируулах	Үзүүр	371
2	Өргөлт хийсэн	п/м	1512.5
3	Хөөлтийн тээг шахсан	ширхэг	1490
4	Давталт хийсэн	п/м	1075
5	Чиг татсан	п/м	275.5
6	Дэр мод сольсон	ширхэг	154
7	Дэрийн эпюр тохируулсан	ширхэг	34
8	Уулзварын зай тохируулсан	п/м	300
9	Замын зэрлэг, габарит цэвэрлэсэн	п/м	2862.5
10	Боолт нөхсөн, чангалсан	Удаа	114
11	Хадаас нэмж, сольж хадсан	Ширхэг	130
12	Сумны бэхэлгээ чангалсан	Удаа	132
13	Подрельс гаргах	п/м	1462.5
14	Дүнз сольж хадах	ширхэг	81

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- Чиг заагч тохируулах , закладка гагнах, шор тоонолж, хаших, заклатка, I,II татуурга, блансерь будах, шорны тулах тохируулах, шамралт арилгах, босоо хажуу зөрүү арилгах, ташсан дэр тэгшлэх, гарам хийх, замд тогтсон ус шүүрүүлж урсгах, материал цэгцэлж хураах, ажлын байрны цэвэрлэгээ хуучин дэр оруулж хураах, башмак шорны уланд шахуулах, зүлгэж өнгөлөх, шорны ажим арилгах, цас цэвэрлэх, алхам тохируулах, дэр мод, дүнзний паспортын үзлэг хийж, вагон пүүний ивүүрт гагнуур хийсэн, замын дугаар шинээр бичсэн. Экскаватор багана хооронд ухуулж багана чөлөөлж, жигд урсгалтай болгосон.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй хийгдсэн ажлууд, шалтгаан нөхцөл:


- 8-р сумны II татуурга
- ИТ 7385-г засварт явуулах
- Чиг заагч тохируулсан
- Платформд думпкарын шал ачуулж 23-р замд буулгасан
- Тахийсан шор матсан
- Молодок, хүрз ишлэв
- Закладка гагнуулсан

- Бялт, курбельт хайрцаг хийж цоожтой болгосон
- Зэвэрсэн боолт сольж тавьсан
- Цариг баригч татуурга хийсэн
- Р50, Р43 шилжих хавчаар хугарсныг сольж тавьсан, боолт, ивүүр, хавчаар сольж боосон
- Сагалт үүссэн дэрүүдийг цэвэрлэж шинэ балласт хийж чигжсэн
- Вагон пүүнд гагнуур хийлгэсэн
- Блансерь сольж тавьсан, хугарсан, гагнуулсан
- 8-р замд хугарсан зам төмөр сольж хадсан
- Бүх сумны башмак зүлгэж өнгөлсөн
- Тэмдэгний нүх ухуулсан
- Экс гаргах бэлтгэл ажил хийгдсэн
- Вагоноос нүүрс буулгах гарам тэмдэг тавьсан

ЗУРГАА. МЕХАНИК ЗАСВАРЫН ХЭСЭГ

Гүйцэтгэл хувиар: Нийт техникийн бэлэн байдал 88% гүйцэтгэлтэй ажилласан байна.

График 19



Нийт техникийн бэлэн байдал **88%** гүйцэтгэлтэй ажилласан байна.

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

Хүснэгт 13

Техникүүд	Тоо ширхэг	Нийт засварт зогссон цаг	Хийгдсэн ажлууд
Цахилгаан экскаватор	6	4464	<p>ЭКС №36; №42 жилийн засвар хийгдэж шаардлагатай сэлбэг материалуудыг сольж тавьсан байгаа.</p> <p>Экс №37 Явах ангийн хацар, зүрх араа холхивч засвар, напорын тросс сольсон.</p> <p>Экс №38-ийн сумны секц салгаж гагнуур засвар, сумны татуурга, напор, подъемны тросс сольсон.</p> <p>Экс №39 зөөвөр нүүдэл хийж харуулд хүлээлгэн өгсөн.</p> <p>Hitachi 1900 Мотт цагийн үйлчилгээ хийгдсэн.</p> <p>Генератор хөдөлгүүрийн гэмтэл нь ихэвчлэн удаан хугацаанд ашиглагдсанаас ротор статорын ороомог секц катушкын тусгаарлагчийн чанар муудсанаас ачаалалд их орох, шпонк элэгдсэн, холхивч нурсан, хэт ачаалал зэргээс халалт их үүснэ.Фаз хоорондын, ороомог тасрах,оч хаях,хэт халах,механизмыг хэт ачаалал, хөргөлтийн систем муу шалтгаанаас, мөн бригад ээлжийн эхэнд, дунд, төгсгөлд үзлэг хийгээгүйгээс болж гэмтэл их дунд засвар хийхэд хүргэж байна. □Шанага, втулка, ган зам, роликууд элэгдэж гагнаж зордог Тэсэлгээний чанараас хамаарч ажлын механизм болх ганага ханзрах шүд хугарах балк хугарах тросс тасрах гэсэн гэмтлүүд гардаг</p>

Гидро экскаватор	3	4328	<p>Hitachi 1200 шинэ мотор сольсон, захын дамжуулагчийн хагас гол солисон.</p> <p>Hyuindai 520 Моторын ээлж захиалж боож тавьж ажилд гаргав.</p> <p>Hitachi 870 Моторын ээлж захиалж боож тавьж ажилд гаргав.</p> <p>Палец втулка, шанага ханзрах, буйль тасрах, шүд элэгдэх, хугарах зэрэг нь: Уулын цулын тэсэлгээний чанараас хамаарч хатуулаг ихтэй ажлын талбайд хэт ачаалалтай ажилласнаар дээрхи гэмтлүүд их гарч байна. 1900, 1200-ийн шүд сэргээн засварлах ажил хийгдэж байна.</p>
Коматцу HD465	5	5736	<p>№37 мотор тавьж ажилд гаргав.</p> <p>№38 мотор задалж оношилгоо хийж ээлж захиалж боож ажилд гаргав.</p> <p>№39 тормозны систем оношилгоо хийж насос тавьсан, богино кардан зөөлөн холбоо сольсон, моторын духны сальник сольсон.</p> <p>№40 Холбоос палец втулька сольсон</p> <p>№44 мотор задлаж оношилгоо хийсэн ээлж захиалж угсралт засварын ажил явагдаж байна.</p> <p>Сэнсний ремин, шкыв, татуурганы палиц втулка, захын дамжуулагч, богино голын тахо савах савалгаа үүсэх, шаариг нурах, амертизатор ажиллагаагүй болох, гагнуурын ажлууд. Коматцуны мото цаг 30-40 мянган мото цаг хэтэрч капитал засварт орох болсон тул техник нь цаг ашиглалт, зогсолт их байна. Иймд шаардлагатай сэлбэг материалыг ханган нийлүүлэх. Өөр харилцагч судлах.КОМ 40,38,39 хөдөлгүүр их засвар хийгдсэн.Татуургыг Гео Маш аар хийлгэж туршилтаар явуулж байна.Бүх комацунуудын хойд тэнхлэг салгаж элэгдэлтэй холбоос палец втулканы үүрийг зөөврийн токарь буюу БОРН хийсэн</p>
CAT 773D	5	5304	<p>№221 үзлэг оношилгоо хийж дутуу сэлбэгийн жагсаалт гаргаж сэлбэг захиалж угсралт засварын ажил явагдаж байна.</p> <p>№222 Моторын даралт унасан үзлэг оношилгоо засвар хийгдэж ажилд бэлэн болгов.</p> <p>№224; 225 мотор задалж оношилгоо хийж мотор ээлж захиалж боож тавьж ажилд бэлэн болгож алтанд хүлээлгэн өгсөн.</p>
Бульдозер	3	4200	<p>CAT D9 явах ангийн угсралт засвар хийгдэв. Кропны оношилгоо хийгдэж засварлав.</p> <p>Комatsu 275 явах ангийн гинж сигмент захиалж сольж тавьж ажилд гаргав.</p> <p>Комatsu 375 кроп авч гоожилт зогсоож, тормозны хуваарилах, насос сольж тавьж оношилгоо засвар хийгдэв.</p>

			Пирекцион, мотор, явах ангийн катки, гинжний втулка хагарах чиглүүлэгч дугуй, одон дугуй, хутганы ир гэмтлийн шалтгаан нь гинжит механизмыг хол замд хэт ачаалалтай явуулсанаар явах эд ангид халалт үүссэнээр дээрхи гэмтлүүд гарч байна.
Автогрейдэр	2	2520	<p>САТ 16G моторын сапунаар утаа хаясан. Мотор болон урд тэнхлэг захиалсан угсралт засварын ажил явагдаж байна.</p> <p>Komatsu 655 моторын крышканы жийрэг үлээсэн 6-р цилиндрийн кольц хугарсан угсралт засварын ажил хийх.</p> <p>Урд тэнхлэгний бүх палец втулгыг зорж хийсэн Урд 2 цапфын гол хугарсныг зорж угсралт хийсэн, Урд цапфа хөндлөн татуурганы гар хугарсаныг зураг гаргаж шинээр хийж угсарсан</p> <p>Өндөр даралтын түлшний насос, мотор, ажлын хүрдний цилиндрүүд, цафь, хутганы ир, дугуй. Урд тэнхлэгний палец втулка урд цап ажлын хүрдний цууралт гэсэн гэмтлүүд гарч байна.</p>
Дугуйт ачигч	2	864	<p>SD200 мотор, кропны масло гоожилт зогсоох. Салхины шил хагарсан захиалсан сольж тавьж ажилд гаргах.</p> <p>SD300 Мотор, кроп засварлаж ажилд гаргасан. Агтлах санал оруулах.</p>
ХЕМС	4	1752	<p>Бүх ХЕМС-д дугуйн хошуу сольсон хошууны хамгаалалт хийсэн Т/Ү чангалгаа тосолгоо хийж шётка, шётка баригч сольсон.</p> <p>Тормозны аппаратны сальник накладка труба Урд амортизаторын болт сулрах хугарах,сальник Цахилгаан хэлхээний плат компьютеруудын гэмтлүүд гарч байна</p>
Hitachi 1700	3	13032	Мотор авч УБ Cummins ХК руу явуулсан мотор тавьж асааж шалгаж хүлээлгэн өгсөн.
HOWO 371	7	7628	<p>№71,74,76 мотор цохисон задалж оношилж боож ажилд гаргасан. Шинээр мотор захиалж холболт хийж асааж шалгаж ажилд гаргав. Бүх техникт Т/Ү хийж накладка, блансир, хагас гол, подъемны насос, жижиг кардан тогтмол үзлэг хийж сольж ажилд бэлэн болгож ажиллав.</p> <p>Кропны гожухны болт тасрах, Мотор кропны гожух хагарч, муфть шарик, нум, перда диск, ган диск, яндан турба, рычажны хос тросс, подъемны жижиг кардан, хийн трүпп, урт карданы болт, хагас гол. Сэлбэгийн лимит хэтэрсэн тул төсөвт шинээр суулгах тал дээр санхүү болон хангамжтай тохиролцсон захиралд танилцуулах ажил явагдаж байна.</p>

- Уул уурхайн бүх техник тоног төхөөрөмжид урьдчилан үзлэг оношилгоо, мото цагийн үйлчилгээ хийж, гэнэтийн эвдрэл гэмтэл сул зогсолт гарахаас урьдчилан сэргийлж шаардлагатай сэлбэг материалыг захиалж угсралт засвар хийж сул зогсолтгүй ажиллалаа.

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд:

- Экскаватор №37-ийн шанаганын балк хугарсан. Тэсэлгээ муу хийгдсэнээс болж ачилт хийгдэж байх үед том чулуу нурж шанаган дээр унаж балк хугалсан.
- Экскаватор №38 тэсэлгээгүй мөргөцөгт ажиллаж байгаад саравч болсон шороо шанаган дээр нурж бантны тросс мултарч сумны дээд, доод секцны холбоос салж балк гулзайсан.
- Эдгээр гэнэтийн төлөвлөөгүй эвдрэлийг гадны компаниар хийлгэх гэж судалж үзсэн боловч хугацаа удаан, ажлын хөлс их байсныг бид өөрсдөө салгаж авч гагнаж угсралт хийж ажилд бэлэн болгосон.

Зураг 8



- Цар тахлын эрсдэлтэй хүнд үед хэсгийн ажилчдыг уурхайн бүсэд байрлуулж үндсэн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд нь зохион байгуулж ажилласан.
- Засварын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор багажны өрөөтэй болгосон
- Даралтат савыг хадгалах саравчийг шинээр хийж ашиглалтад оруулж ХАБ-тай зөвлөлдөж гадна байрлуулсан
- Даацын дугуйт техникуудийг хийлэх үед нух төмөр харвахаас сэргийлж, аюулгүй байдлыг хангах зорилгоор дугуйн хорио хаалт хийсэн.

ДОЛОО: ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ХЭСЭГ

- ❖ Төлөвлөсөн ажлын тоо: 112
- ❖ Биелсэн ажлын тоо: 111
- ❖ Гүйцэтгэл: /хувиар/ 99%

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

- Экс№38,51-ийн ЯКНО-д реле хамгаалалтанд Микропроцессийн /Vamp-57/ программ суулгаж тохируулга хийсэн
- ХХБ-№1 ячейк№22, КРУ-22-оос шаазгайтын орд руу 2.4км ӨХЦДАШугам шинээр татаж босгоно. Хүчдэлд холбож зүгшрүүлэлт хийсэн.
- ЕХ-1900 экс№51, ЭКГ-8И экс№38-ийг Шаазгайтын орд руу нүүлгэж байрлуулсан.
- ЦДАШ №12-г шинээр сэргээж Экс №36-г оруулан, ЦДАШ №14-ийн ачааллын хөнгөлөлт хийж, хүчдэлийн тасралтгүй болгосон.
- Экс №51, экс №38-ийг Шаазгайтын ордоос нүүлгэж Үндсэн мөргөцөгт оруулж байрлуулах, АШ шилжүүлэх, барих
- РУ-1 Яч№1-Яч№5, Яч 10-РВО-6 тус бүр 1ш цэнэг шавхагч солих ажлыг хийж хэт хүчдлийн хамгаалалтыг хэвийн болгосон.
- Тэсэлгээний агуулах контейнерыг газардуулгын байгууламжтай холбож стандарт шаардлагад нийцүүлэн хийсэн.
- Аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөөврийн чарга-2ш бетоноор цутгаж, туршиж байна.
- ЭШ 10/70-ийн өргөх, эргэхийн генераторуудын засвар үйлчилгээ хийж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Экс №38-ийг Шаазгайтын ордоос нүүлгэн үндсэн орд руу нүүлгэхтэй холбогдуулан шугам шилжүүлэг хийж оруулсан.
- Экс №37-г нүүлгэж ажиллах мөргөцөгт байрлуулах зорилгоор ЦДАШ №3-ийг шинээр шилжүүлэн барьсан /2,2км/
- Депогийн Дэд станцад чадлыг өсгөн 630кВА трансформатор шинээр суурилуулан монтажлав.
- ХХБ№1-Яч №9, Яч №4-д Вакум таслуур суурилуулж РХ-ын холболт тохиргоо хийв
- ИХБ№3-аас гарсан ЦДАШ-ыг аюулгүй ажиллагааг хангах зорилгоор КШ-аар солив
- Техникийн бэлэн байдлыг өсгөх зорилгоор Эргэх-100кВт хөдөлгүүр нөөцөд засварлаж бэлдсэн
- ХБ-ийн өрөөний дулааныг сайжруулах зорилгоор РУ-2-т халаагуур-1ш шинээр хийсэн.
- Уурхайн амралтын 12-р шугамын өмхөрсөн 8ш мод сольж, 3ш хөлний чангалгаа хийсэн.
- РУ-1-Орол №1-ийн ЦДАШ-ын 2ш тулгуур шилжүүлэн байрлуулж үйлдвэрийн талбайн аюулгүй байдлыг хангасан
- Хуучин буудлын цахилгааны монтажийг бүрэн хийж дуусгасан.
- Уклон -7-ийн ЦДАШ-ыг өөрчилж шинээр 4 опор нэмж сунгаж холбосон.
- Ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр МЗХ-Уулын цех, ТДХ-ийн дотор гэрэлтүүлгүүд хийгдсэн.
- ХХБ№1, ХХБ№2, ИХБ№3 бүх ячейкүүдэд релей хамгаалалтыг өвлийн горимд шилжүүлэн тохируулсан
- Экс №42,38, 36-ийн хөдөлгүүр генераторуудыг өвлийн горимд шилжүүлсэн

- ТДХ-н 125-р конвейерийн 110квт хөдөлгүүр засварлав.
- Экс№38-ийг ӨХЦДАШ №9-д оруулж Экс №51-ийг дангаар нь ЦДАШ №3-д шилжүүлснээр зогсолт саатал арилсан.
- Экс№37-д Ерөнхий хөдөлгүүр болон дотоод хэрэгцээний сэргээлтийн генераторын статор, якорь засварлан бэлдсэн.
- Тр-ын дэд станц, гэрэлтүүлгийн мачтыг карьерт байрлуулж тэжээлд холбон ажлын мөргөцгийн гэрэлтүүлэг хийсэн.
- Харуулын 4-р пост болон 29-р замд нэмэлт гэрэлтүүлэг тавьсан
- Нөөцөд эргэхийн 100квт хөдөлгүүрийн якорийн секц ороож суулган 1ш якорь нөөцөд бэлдсэн
- Өндөр нам хүчдэлийн ЦТТ болон цахилгаан тоноглолуудын үзлэг үйлчилгээг графикайн дагуу хийж гүйцэтгэсэн..
- Тусгай зориулалтын машины өрмийн хошуу шинээр толгой зоруулж тааруулж тавьсан.
- ЦДАШ №22, 29-ийн тулгууруудад дугаар тавих
- Нүүрсний лабораторийн цахилгааны монтаж шинээр бүрэн хийсэн.
- Нөөцөнд 630квт Синхрон хөдөлгүүрийн статорын секцийн изоляцийг сэргээн ороож суулган 1ш статор бэлдэх.
- Нөөцөд эргэхийн 100квт хөдөлгүүрийн якорийн секц ороож суулган 1ш якорь нөөцөнд бэлдэх.
- ГУШХ-ийн 75квт-ийн цахилгаан хөдөлгүүр нөөцөнд ороож бэлэн болгоно.
- Нөөцөнд 60квт-ийн 1ш якорийн хугарсан гол залгаж засварлан ажилд бэлэн болгоно. /Экскаватор №42-т/
- Уурхайн амралтын ӨХЦДАШ-№12- оролын ЯКНО-10У1 шинээр бэлтгэнэ
- Тусгай зориулалтын машины краны тросс сольж зүгшрүүлэлт хийх
- Тусгай зориулалтын машины өрмийн хошуу шинээр тааруулж толгой зоруулж тавих
- Шаазгайтын ордод газардуулгын байгууламж 1-ийг барьсан
- Шаазгайтын ордод аянга зайлуулагч барьж байгуулах-1ш
- ЦДАШ-ын КРУ №22-г РВО-6 шинээр тавьж туршсан
- Уурхайн амралтын 12-р шугамд өмхөрсөн 10ш тулгуур сольж, 5ш тулгуурын хөлний чангалгаа хийсэн
- Тэсрэх материалын агуулахын трансформаторын дэргэдэх газардуулгын байгууламжийн холболтыг гүйцээж хийсэн
- ЭШ 10/70-ийн хөд-генераторуудын засвар үйлчилгээ хийх
- ЦДАШ-ын унжилт бүхий хэсгүүдэд чангалгаа хийх
- Цахилгаан байгууламжийн газардуулгын хүрээ, хэт хүчдэлийн хамгаалалтын туршилт баталгаажилт хийлгэх
- Нүүрсний лабораторийн цахилгааны монтаж шинээр хийх
- Экс №37-г нүүлгэж хангамжийн хашаанд байрлуулах
- Депо дахь 400ква трансформаторын кабелийн хөндлөн огтлолыг нэмэгдүүлж
- Сольсон



Экс №51, Экс №38-ийг Шаазгайтын орд руу нүүлгэж байрлуулах, мөн буцаан нүүлгэж үндсэн мөргөцөг рүү оруулахаар шинээр ЦДАШ барих, шилжүүлэх ажлууд



Экс №38-ийн ЯКНО-г вакум таслуур, микропроцессорын VAMP релейгэертонголож, ХХБ№1-Орол№20-Яч№9, ХХБ№1-Орол№1-Яч№4-ийн тосон таслууруудыг Вакум таслуураар сольсон байдал



ЦДАШ №12-ыг сэргээн засварлаж мод солих, зарим тулгуурыг төмөр бетон тулгуураар сольж байгаа байдал



14ш модны суулгац суулгаж, 1200 м² талбайг зүлэгжүүлсэн

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- ӨХЦДАШ №14-ийн трассыг өөрчилж шугам барьсан /Хөрс хуулалтын талбай чөлөөлснөөр хөрс хуулалтын ажил хэвийн явагдсан/
- ӨХЦДАШ №14-ийн трассыг дахин өөрчилж шугамыг шилжүүлж барьсан. /Уулын ажлын өрнөлттэй уялдан АА-г хангах шаардлага гарсан тул/
- Ус шүүрүүлэх зорилгоор ЦДАШ №14-д ПКТП-250 трансформатор холбож насосыг ажилд оруулсан
- Зүүн жигүүрийн ус татах ажилд насосны хүчин чадал хүрэлцэхгүйгээс болж ПКТП-400 ква трансформатор тавьж 250квт-ын хөдөлгүүрийг холбож ажилд оруулсан /Энэ ажил хэвийн горимд орсон/
- ГУШХ-ийн насосны 75 квт хөдөлгүүр-3ш ороож ажилд оруулсан.
- ТДХ-ийн 22квт хөдөлгүүр-1ш ороож ажилд оруулсан.

НАЙМ: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

Зорилго:

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах цаашид тэг болгож олон улсад зөвшөөрөгдсөн үр ашигтай компани болохын тулд ISO 45001-2018 стандартыг нэвтрүүлэх нь тулгамдаж буй асуудал гэж үзэн, бэлтгэл ажлын хүрээнд доорх зохион байгуулалтыг хийж байна.

Дархан Уул аймгийн “ЧБББА” ТББ-тай хамтарч стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Нэг. Компанийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж нөхцөл байдлаа тодорхойлох:

- Компанид бүрдүүлж буй ХАБЭА-н баримт бичигт анализ хийж, стандартад нийцүүлэх - ХАБЭАХХ-ийн хэлтсийн баримт бичгүүдийг сайжруулах жагсаалт гарсан. 64 төрлийн бичиг баримтаас 58 бичиг баримт шаардлага хангаж байгаа боловч сайжруулалт хийх шаардлагатай 6 бичиг баримт нэмэлтээр хийх шаардлагатай ба стандартад нийцүүлж 5 төрлийн бичиг баримтуудыг боловсруулж батлуулсан.
- ХАБЭАХ-ийн бүтэц зохион байгуулалтын харьцуулсан судалгааг хийж, боломжит хувилбарыг сонгох- ХАБЭАХ-ийн бүтцийг ижил төстэй 4 байгууллагатай харьцуулан судалж “Шарын гол” ХК –д тохиромжтой гэж үзсэн 3 хувилбарыг санал болгосон. Хэлтсийн бүтэц, орон тоог нэмэгдүүлж нийт 15 ажилтан үүнээс хэлтсийн дарга 1, ХАБЭАХХ-ийн ахлах ажилтан 1, тодорхой чиглэлийн хяналт хариуцсан ХАБЭАХХ-ийн ажилтан 5, эрүүл ахуйч их эмч 1, бага эмч 4, байгал орчны мэргэжилтэн 1, дотоод хяналт хариуцсан ажилтан 2 тус тус ажиллахаар, хэлтсийн нэр нь ХАБЭАХХ-элтэс байхаар тусгагдаж батлагдсан ба одоогийн байдлаар нийт 11 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.
- Процессын зураглал боловсруулах сургалт хийгдсэн - Процессын зураглалын сургалтыг 3 удаа хийж, “Шарын гол” ХК –ийн ХАБЭА –н ажлын процессын зураглал хийхээр томилогдсон хөгжүүлэлтийн багтай хамтран нийт 14 процессын зураглал гаргасан ба ажлын явцад мэргэжлийн зөвлөмж, арга зүйгээр хангаж ажилласан.
- Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээний үр дүн, санал зөвлөмжтэй холбоотой сайжруулалт хийх - Өнөөгийн төлөв байдлын шинжилгээний үр дүн нийт 3 бүлэг 9 зүйл, ерөнхий дүгнэлт, зөвлөмж, сайжруулах санал бүхий тайлан гарган ирүүлсэн ба стандарт нэвтрүүлэлтийн ажлын төлөвлөгөө гаргаж, ажлын хэсгийг томилон, ХАБЭАХХ –ийн бүтэц орон тоог нэмэгдүүлэх, ажлын байруудын процессын зураглал болон эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.
- Зөвлөмж, үр дүнг тайлагнах, танилцуулах – “Шарын гол” ХК –ийн өнөөгийн төлөв байдлын судалгааны үр дүнгийн тайлан болон ISO45001:2018 чанарын гарын авлага боловсруулан, “Шарын гол” ХК –ийн удирдлагын баг болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулан хүлээлгэн өгсөн. Өнөөгийн төлөв байдлын судалгаан дотор ерөнхий дүгнэлт, сайжруулах санал, зөвлөмжийг гарган танилцуулсан.

Хоёр. Ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж шинэчлэх:

- Шаардлагатай удирдах ажилтнуудын АБТ-ыг авах /Цехийн дарга, ээлжийн мастер, ИТА/ - Анхан болон дунд шатны менежерүүд, ХАБЭА –н ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт боловсруулалтын өнөөгийн байдлын судалгаа хийж, анхан дунд шатны менежерүүдийн ажлын байрны тодорхойлолтонд 4, ХАБЭА–н ажилтануудын ажлын байрны тодорхойлолтод 6 дутагдалтай зүйлийг илрүүлэн залруулах санал оруулсан.
- Ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, үүрэг хариуцлагыг тодорхой болгох - ЗХНХ-ийн ажилтнуудтай зөвшилцөж ажлын үүргийн давхардлыг арилгах, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, ажлын байрны тодорхойлолтын боловсруулалтыг сайжруулах чиглэлээр 6 төрлийн санал гаргасан.
- Тайлан, зөвлөмж боловсруулах - Ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж, тайлан, зөвлөмж боловсруулах хэсгийг компанийн өнөөгийн төлөв байдлын судалгааны тайлангийн 2 –р бүлэгт оруулсан. Ажлын байрны тодорхойлолтууд дээр ажиллахдаа ХАБЭА–н болон холбогдох бичиг баримтын хуулийн нийцлийн үнэлгээ, анхан дунд шатны менежерүүдийн ХАБЭА–н мэдлэгийн шалгалт-үнэлгээ-дүгнэлт, ХАБЭАХХ–ийн өнөөгийн төлөв байдлын судалгаа, сүүлийн 17 жилийн үйлдвэрлэлийн осол, МШӨ –ий нөхцөл байдлын судалгаа, ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг нэгтгэн хийж, эдгээрт үндэслэн сайжруулах санал, тайлан, зөвлөмжийг уг бүлэгт тусгаж оруулсан.
- Зөвлөмж, үр дүнг тайлагнах, танилцуулах - Компанийн удирдлагын бүрэлдэхүүн, ажлын хэсэгт ажлын байрны тодорхойлолтуудыг сайжруулах санал зөвлөмж, анхан дунд шатны менежерүүдийн ХАБЭА–н мэдлэгийн шалгалтын дүгнэлт, үйлдвэрлэлийн осол, МШӨ–ний судалгаа, дүгнэлт, ХАБЭА–н үйл ажиллагааны SWOT шинжилгээ зэрэгт үндэслэн, зөвлөмж үр дүнг тайлагнан танилцуулсан.
- Удирдлагын баг, ХАБЭАХХ, ИТА нарт АБТ боловсруулах сургалт зохион байгуулах - Ажлын байрны тодорхойлолт боловсруулах талаар зөвлөмжийг танилцуулсан.

Гурав. Ажлын байрны зураг авалт хийх

- Эрсдэлтэй 20 ажлын байранд зураг авалт хийж, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааг авсан ба түүнд тулгуурласан дүн шинжилгээг хийж 5 төрлийн зөвлөмжийг гаргасан.
- Ажлын байрны зураг авалт, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ болон зөвлөмжийг удирдлагын баг, ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, зөвлөмж өгсөн.
- Зөвлөмж, үр дүнг мэдээлэн, чанарын гарын авлагад тусгаж өгсөн.

ЧБББА –ын зөвлөмжийн дагуу стандартад нийцүүлэн зохион байгуулсан ажил

Нэг. ХАБЭАХХ-т хөндлөнгийн аудит хийлгэж үйл ажиллагааг сайжруулах

- Төлөвлөгөөний дагуу нийт үндсэн 14 процессийн зураглал хийгдэж, 20 цагийн сургалт орсон байна.үүнээс ЧБББА-8 цаг, сургалтын төвөөс 12 цаг орсон байна.
- Уурхайн хэмжээнд одоогоор үндсэн 288 процессийн зураглал хийх ба ажлын хэсэг төлөвлөгөө гаргаж ажиллаж байна.
- Хөтөлбөрийн дагуу ажил хийгдэж байна.

- ХАБЭАХХ-н бүтэц орон тоо хуулийн шаардлагад нийцүүлэн 2021.07.01 наас шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллаж эхэлсэн.
- ISO45001 стандарт танилцуулах сургалт хийгдэж байгаа ба стандартыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх компаниас сургалтыг үе шаттай авах.
- Уурхайн сүүлийн 17 жилийн осол аваарын мэдээллийг нэгтгэж мэдээллийн санд дүгнэлт гаргаж өгсөн ба ХАБЭА-н чиглэлдээ сайжруулалт хийгдэхгүй бол осол аваарын тоо ирэх жилүүдэд өсөхөөр прогноз гарсан тул шууд ба шууд бус шалтгааны олох судлах ажлыг эхлүүлж эрсдэлд суурилсан ХАБЭА-н сургалтууд хийгдэж байна.

Хоёр. ХАБЭА-ын бодлогын баримт бичиг боловсруулж хөтөлбөр гаргах

- Компанийн ХАБЭА-н бодлого бичиг баримт батлуулсан
- Батлагдсан бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэхийн тулд ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргах - Хэрэгжилтэд хяналт тавьж, засаж сайжруулж ажлыг үе шаттай хийнэ.

Гурав. Орчин нөхцөл сайжруулах чиглэлд хийсэн ажил, зам арчлалт, шат тавцан, тэмдэг тэмдэглэгээ

- Нийт 5 объект 53 цэг дээр хэмжилт хийгдэж зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байгаа хэсэг нэгжийн ажлын байруудад гэрэлтүүлгийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулалт хийгдэж дууссан нэмэлтээр 24 ш аваарын гэрлүүд байршуулж байна.
- Мэргэжлийн байгууллагаас дээрх хэсгүүдийн агааржуулалтын системийн зураг гаргуулж, зөвлөх үйлчилгээ авсан ба агааржуулалтыг сайжруулах ажил хийгдэж байна.
- Байнгын болон бүх замуудын паспортууд хийгдсэн ба эргэлт тойруу хэсгүүд дээр хэмжилт хийгдсэн ба шаардлага хангахгүй 4 үндсэн замаас 2 замд сайжруулалт хийгдсэн ба 2 замыг өөрчлөх зураг гарсан хавар хийхээр төлөвлөж байна.
- Шинээр 2 зэхэлтийн талбайг хийж тэмдэгжүүлж, 2 паркийн талбайг хийсэн.
- НААХ-ийн шат тавцан өөрчлөн сайжруулах ажил хийгдсэн
- Нэн түрүүнд аюулгүй ажиллагаа, ноймор дугаар хийсэн. 4 ХЕМС,8 хово,4 комацу, 855,16G
- Шөнө гэрэлтдэг хуулга хийгдэж эхлэж байна
- Бүх зам талбайд шинээр тавих болон сайжруулалт хийх тэмдэг тэмдэглэгээ, бэлтгэл ажил хангагдсан НААХ-ийн нийт 1 тавцан, 3 шат сольж шинэчлэн сайжруулсан.

Сургалт, зааварчилгаа

- Нийт ажилтны сургалтын хөтөлбөрт оруулж, ажилтнуудад танилцуулсан нийт 395 ажилтан хамрагдсан
- Нийт ажилтны сургалтыг 11 сэдвээр 12 цагийн сургалтад 409 хүнээс 395 хүн сууж шалгалт авсан.
- Даралтад савтай харьцах эрх авах,эрх сунгах 61 ажилтан сууж үнэмлэх авсан
- Нийт ажилтны сургалтын Төлөвлөгөөний дагуу сургалт орсон нийт 395 ажилтан хамрагдсан
- “Дазл” ХХК 25 хүн нийт ажилтны сургалтад хамрагдсан.

- ISO 45001 ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоотой холбоотой хэсэг хэлтсийн 2 удаагын сургалтаар 12 удирдах албан тушаалтнуудад сургалт орсон.
- Сүүлийн 17 жилийн судалгааг жилээр болон сараар гаргасан хийгдсэн, ҮО-д хүргэдэг аюултай хүчин зүйлс, холбоотой нийт ажилтны сургалтад 395 ажилтан сургалтад хамрагдсан
- Нийт ажилтны сургалтад зохих сургалтуудыг явуулж, арга барилыг сайжруулж байна. нийт суусан 395 ажилтан суусан
- Нийт 8 удаагийн сургалт явуулж, хэлтэс нэгж бүр зураглал хийх чадвартай болсон. Нийт 102 ИТА сургалтад суусан
- Аюулыг мэдээлэх Toki аппликейшн нийт хэсэг нэгжүүдийн ажилчид суулгаж хэрэгжүүлж ажиллаж байна.
- УБЭҮ, “Ачит ихт” ХХК танилцах, 14 хүний бүрэлдэхүүнтэй ИТА ажилчид тус бүртээ 14 шинэ санаа дэвшүүлж тайлан хийсэн хэсэг нэгжүүдэд танилцуулга хийсэн. Тухайн байгууллагын ХАБЭАХ-ийн дарга нартай уулзалт хийсэн.
- 5 хүн оролцож сүүлийн үеийн мэдээлэл, авч танилцуулга хийсэн. Шинэ санааг дотоодоо нэвтрүүлж ажиллаж байна.

Эрсдэлийн менежмент

- Уурхайн бүх ажлын байр, ажилбар, удирдлагын тогтолцоонд 288 алхам дээр эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж УНХ-ээс эрсдэлийн үнэлгээний ажил эхэлсэн.
- Шинээр ирсэн багаж, аюулгүй ажиллагааны өндрийн бүс, хувцас хэрэгсэл бүгдийг туршиж шалгаж, портукаль үйлдэж хэрэглэж эхэлдэг эрсдэлийн менежментийн аргачлалыг нэвтрүүлж байна.
- ЧБББА-н судалгааны үр дүн болох уурхайн хэмжээнд сүүлийн 17 жилийн осол, осолд дөхсөн тохиолдлын судалгаанд үндэслэн 2021 оны 7 сард ХАБЭА-ын жилийн төлөвлөгөөг эрсдэлийг тооцоолж боловсруулсан
- 2021.12.01-нээс уг апп эхний 6 сар үнэгүй ашиглахаар хэрэглэж эхэлсэн ба уурхайн хэмжээнд аюулыг цаас ашиглахгүй утсаар илгээж болох боломжийг бүрдүүлж ажиллаж байна.
- Стандарт нэвтрүүлэх эрх бүхий байгууллага хамтарч ажиллах бэлтгэл ажил хийгдсэн.
- Хогийг ангилан ялгах хогийн сав өөрсдөө хийж ашиглаж эхэлсэн ба шатаах боломжтой хогийг шатаах зуух хийх ажил 90% гүйцэтгэлтэй явагдаж байна.
- Гэрээний дагуу нийт 22 тн хаягдал тос, масло Улаанбаатар хотын 2-догч түүхий эд авдаг төвд нийлүүлсэн байна.
- Тос масло, түлшний түр хадгалах цэг бетон суурьтай саравч хийж хадгалж байна.
- 2022 оны БОМ төлөвлөгөөг ISO45001 стандартад нийцүүлж төлөвлөж байна.
- ХАБЭА-н апп ашиглан хяналтын систем нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Уугилттай цэгүүдийг тодорхойлж ууглтлыг багасгах хучилт хийх зэрэг арга хэмжээг авч байна.
- Ус ихээр тогтдог ажлын талбай болох МЗХ блокуудыг топо хэмжилтүүд хийгдсэн 2021.04 сард сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна
- 2022.04 сараас эхлэн шарилжны хор ашиглаж эхлэхээр төлөвлөсөн

- 2021 онд 650 мод тарьсан ба 2022 онд усалгааг нь хүний оролцоо бага байхаар төлөвлөж байна.

“Шарын гол” ХК-ийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги

- Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчлэн зохион байгуулах - Бүтэц зохион байгуулалт үүрэг хариуцлагыг тодорхой болгож тодотгол оруулан батлуулсан
- Цар тахлын үед мөрдөх түр журам боловсруулж хэрэгжүүлэх - ГТХ-нд ковид нөхцөл байдалтай уялдуулж тодотгол хийж батлуулан хэрэгжүүлж эхэлсэн
- Халдвар хамгааллын дэглэм баримталж уурхайн үйл ажиллагааг тасралтгүй явуулах уриа гаргаж хүн бүрийн хариуцлагыг нэмэгдүүлэх - “Хайртай бүхнийхээ төлөө хамтдаа хичээцгээ” уриалга гаргаж 4 удаагийн давтамжтай аян хийж хэлтэс нэгж бүр нарядын дараа уриалгаа хэлж хэвшсэн.
- Ажлын байр бүрт ОК-н зааврын дагуу ариутгал хийх - 2021 оны 01-р сараас 2021 оны 12-р сарыг дуустал – 514 удаа ажлын байрны ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.
- Уурхайн бүсэд халдвар тархаахгүйн тулд мэргэжлийн ангийн шийдвэрийн дагуу ажиллах - Уурхайд нэвтрэх бүрт халууныг хянаж, түргэвчилсэн шинжилгээг 7 хоног тутамд бүх ажилтнаас авч урьдчилсан сэргийлэх тактик барьсан ба нийт-4115 удаа түргэвчилсэн шинжилгээг давхардсан тоогоор хийсэн байна.
- Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих - Ажиллагсдын дархлаажуулалтыг дэмжих, витаминжуулах зорилгоор - Витамин С-1000мг, Витамин Д-4000мг/ -430 ажилтанд, Дархлаа дэмжих багц /Вакус, Хар сармисны ханд, Хор тайлах цай/ нийт 420 ажилтанд олгосон байна.
- Вакцинжуулалтын 1,2 тунд нийт 419 ажиллагсдыг, 3-р тунд нийт 394 ажилтныг хамруулсан. Нийт ажилтны 94,8 хувь нь 3-р тундаа хамрагдсан байна.
- Ажиллагсдын хоолны амт чанар, эрүүл ахуйд ээлж тутамд хяналт - 39256 удаагийн хяналт тавьсан.
- Халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, сахилга баттай байлгах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх - Гал тогооны хэсэгт бүх ширээн, хоол олгох хэсэгт хаалт хамгаалалт хийсэн ба ингэснээр хоолонд орох үед халдвар хамгааллын дэглэм баримтлан бүрэн боломжтой болсон.
- Хүмүүсийн бөөгнөрөл үүсгэхгүй байх чиглэлд нэг дор 3 дээш хүн бөөгнөрч ажиллах, зогсох хориглосон ба тамхины цэгийг нэмэлтээр 15 цэг байгуулж өгсөн.
- ГЭР-АЖИЛ, АЖИЛ ГЭР санаачилга гаргаж хариуцлагатай уурхайчин уриалга гаргаж хяналт тавьж ажилласан.
- Онцгой комиссын шийдвэрүүдийг мөрдлөг болгож ажиллах, мэдээ мэдээллээр шуурхай хангах Улс, аймаг, сумын онцгой комисстой тогтмол хамтран ажиллаж аливаа гарсан шийдвэр бүрийг хэлэлцэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, шаардлагатай мэдээ мэдээллийг гаргаж мэдээлж байв.
- Цагийн байдлыг зөв үнэлэн, гарч болзошгүй эрсдэлийг тооцон, уурхайн үйл ажиллагааг тасралтгүй явуулах - Хэлтэс нэгж бүрт онцгой нөхцөл байдалд ажиллах хүн хүч зохион байгуулалтын төлөвлөгөөг 4 удаа шинэчлэн гаргаж хийх ажлын график гаргаж ажилласан.
- 2021.03.22 – ны өдрөөс 2021.05.22 өдөр хүртэл хамгийн бага орон тоо буюу 55 хүний бүрэлдэхүүнтэй ээлжийг зохион байгуулж, ажиллагсдыг байрлаж ажиллуулан эрсдэлтэй нөхцөл байдлыг амжилттай даван туулсан.

- 2021.08 сард улс орон даяар баяр наадмын дараах халдвар тархалтын өрнөл давтамжийн үед 7 хоногт 20 орчим хүн халдвар авч уурхайн үйл ажиллагаа зогсох хэмжээнд хүрсэн тул 2 дахь удаагаа 28 хоногийн хөл хорио тогтоож уурхайн хэвийн үйл ажиллагааг зогсоохгүй даван туулж чадсан.
- Уурхайн яаралтай тусламжийн 95953103 дугаарыг 24 цагаар ажиллуулж ажилтнуудад зөвлөмж, санамж өгч олон талт тандалт судалгааг цаг тухайн бүрт авч, өгч ажилласан.
- Мэргэжлийн ангийн хурлыг 12 удаа зохион байгуулж, цаг үед тохирсон 4 удаагийн төлөвлөгөө, 28 ажил хийх шийдвэрийг шуурхай гаргаж, бүлэг тус бүрт тодорхой үүрэг даалгавар өгч ажилласнаар уурхайн үйл ажиллагааг тасралтгүй явуулсан. Хурал бүрд протокол хөтлөж байсан.

Осол, осолд дөхсөн тохиолдол

- 2021 үйлдвэрийн осол - 2, осолд дөхсөн тохиолдолд - 18 гарсан.
 - 2021.03.03-нд ЦШСХ-ийн ээлжийн мастер цахилгааны тулгуурын хамт унаж амь насаа алдсан.
 - 2021.06 сард ААҮХ-н Эрфолот шатнаас унасан.
 - Осол осолд дөхсөн тохиолдол тухайн бүрт хариу арга хэмжээ авч ажилласан.

ЕС: САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

Санхүүгийн хэлтэс нь: Компанийн үндсэн зорилгыг биелүүлэхэд санхүүгийн оновчтой зөв бодлого баримтлан, өмч хөрөнгөнд бүртгэлээр хяналт тавьж, санхүүгийн сахилга батыг эрхэмлэн, удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй.

Зорилт: Чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна Үүнд:

- Компанийн хэмжээний өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих
- Үргүй зардлыг багасгах компанийн үр ашгийг дээшлүүлэх
- Өглөг, авлагыг барагдуулах, түүнд хяналт тавих
- Ажилчдын цалин хөлсийг журам тушаал шийдвэрийн дагуу бодож олгох
- Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь НББОУСтандартын дагуу үнэн зөв гаргаж тайлагнах

Хэлтсийн бүтэц зохион байгуулалт

- 2021 онд 7 ажилтны орон тоотой ажиллах төлөвлөгөөтэй. Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч-2, материал хариуцсан нягтлан бодогч, цалин хөлс, хэсэг хариуцсан нягтлан бодогч-2, бэлэн мөнгө, ХАБ, бичиг хэргийн складын нярав гэсэн 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажилласан. Тайлант хугацаанд 1 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байсан.

Санхүүгийн хэлтсийн үйл ажиллагаа

А. Компанийн хэмжээний өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавих

- Компанийн мөнгөн хөрөнгийн харилцах данс болон касс, ЖМСангийн сахилга батыг чандлан сахиж 73,0 тэрбум төгрөгний гүйлгээг анхан шатны бүрдэл болсон баримтаар хийж, харилцах дансны үлдэгдэл болон орлогын мэдээллийг удирдлагад танилцуулж хэвшсэн.
- Пос машин нэвтрүүлснээр бэлэн мөнгөний орлого багассан ба үүнтэй уялдуулан бэлэн няравт харилцах дансны интернет гүйлгээг хариуцуулж өгсөн.
- Сэлбэг материалын хувьд тайлангийн хугацаанд 5847 нэр төрлийн 22,409,0 сая төгрөгийн худалдан авалт хийгдэн 6137 нэр төрлийн 23,283.9 сая төгрөгний сэлбэг бараа материалын зарцуулалтыг нярвын тайланг анхан шатны баримтуудтай тулгалт хийж шалган хүлээн авч агуулахын бүртгэлийг баталгаажуулж ажиллажээ.
- Үндсэн хөрөнгө, БҮТЭЗ-ийн тооллогыг жилд 1 удаа, Эргэлтийн хөрөнгийн тооллогыг 2 удаа хийхээс гадна бэлэн мөнгө, хүнсний склад, тосны склад, шатахууны үлдэгдлийг сар бүрийн эхэнд тоолж хэвшсэн.
- Ажлаас халагдсан ажилчдын хувцасны тооцоог нормыг үндэслэн 2,042.5м₮-н хувцас буцаан тушааж, 6,546.2м₮-н хувцасны суутгал хийгджээ.
- Тайлангийн хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарт хяналт тавьснаар жингийн зөрүүнээс 2431 тн нүүрс 108,2 сая төгрөг алдаж, 336,9тн 15,8

сая төгрөгийн орлого олсон бөгөөд илчлэгээс 935,7 сая төгрөгний орлогыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж олж чадсан байна

- Худалдан авагч 140 гаруй, бэлтгэн нийлүүлэгч 220 гаруй байгууллагатай тогтмол харилцаж хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулан авлага өглөг барагдуулалтыг хийж байна. Томоохон хэрэглэгч болох Эрдэнэт ДЦС, Ачит ихт ХХК, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т нийлүүлсэн нүүрсний үнийг дараа сарын 10-ны дотор авч хэвшсэн

Б. Үргүй зардлыг багасгах компанийн үр ашгийг дээшлүүлэх

- Тайлант хугацаанд хаягдал зэс, бочка, цагаан сав, шпал зэрэг ашиглагдахгүй хөрөнгийг үнэлэн борлуулснаар 14,8 сая.төг, сэлбэг материал борлуулснаар 136,7 сая.төг, машин техник түрээсэлснээс 1,237.6 сая төгрөгийн орлогыг оруулжээ.
- Замын сангийн бүртгэлээс суудлын автомашины замын торгуулийн түүврийг хийж холбогдох эздээр нь төлүүлж, мөн ЗГ-н хөнгөлөлтөд хамруулснаар 13 машины 1082,3м,төгрөгний хөнгөлөлт эдэлсэн

В.Өглөг, авлагыг барагдуулах, түүнд хяналт тавих

- Тайлангийн хугацаанд найдваргүй авлагад тооцогдоод байсан зарим авлагуудыг шүүхээр шийдвэрлүүлж Сэлэнгэ энерго ХХК-с 94,4сая төгрөг Гранд повер компаниас 4,4 сая төгрөгийн алдангийг үндсэн төлбөр дээр нэмж тооцож авахаар болов.
- Собу петро ХХК-ийн ШТС-н барилга байгууламжийг хүлээн авч 650,0сая төгрөгний тооцоог данс бүртгэлд тусгасан.
- Хөгжлийн банкны зээл болон хүүгийн төлбөрийн үлдэгдэлд нийт 2507,6 сая төгрөгийг төлж зээлийн тооцоог хааж дуусгасан
- Хэрлэн онон туул ББСБ-н зээл болон хүүгийн төлбөрөөс 4506,4 сая төгрөгийн барагдуулалт хийж өрийн 40%-г барагдуулсан
- Татвар НД-ын байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдлийн төлбөр баргдуулалтанд зөвшилцөж хүрч график байгуулан төлбөрийг барагдуулан ажиллаж байна

Д.Ажилчдын цалин хөлсийг журам тушаал шийдвэрийн дагуу бодож олгох

- Сард дунджаар 420 ажилтны цалин бодох мэдээллийг цуглуулан боловсруулалт, суутган тооцоолуудыг хийж сард нийтдээ 600,0-700,0 сая төгрөгийн цалинг 2 удаа хугацаанд нь банкаар дамжуулан олгож сар бүрийн 5-нд нийгмийн даатгалын тайланг цахим хэлбэрээр болон цаасаар НД хэлтэст өгч байна.
- Ажилчдад олгох цалинг хамтын гэрээнд заасан заасан хугацаандаа цаг алдалгүй олгосон
- Бүтээмжээр ажилчдыг урамшуулах системийг хэрэгжүүлсэн /КРІ/

Ё.Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь НББОУСтандартын дагуу үнэн зөв гаргаж тайлагнах

- Санхүүгийн тайлан тэнцлийг НББОУСтандарт, НББ-н бодлогын бичиг баримтын хүрээнд боловсруулан 2021 оны 2 улирлын болон 2020 оны жилийн санхүүгийн тайлан бэлтгэн Сангийн яамны И-баланс сайтад цахим хэлбэрээр шивж, аймгийн Төрийн сангийн хэлтэст цаасан хэлбэрээр хүлээлгэн өгсөн.

- Улирлаар татварын 8 төрөл, сар бүр 1 төрлийн тайланг e-tax.mn сайтад цахим хэлбэрээр тайлагнаж байна
- Тайлант хугацаанд НББ-ийн аккруэл суурийг баримтлан, анхан шатны баримтуудыг хянан шалгаж, тооцоолон боловсруулалт хийсэн дээрээ тулгуурлан нийт 96601 удаагийн гүйлгээг санхүүгийн программд бүртгэлжүүлэн оруулжээ. Энэ 1 нягтлан бодогч өдөрт дунджаар 72 гүйлгээг шивж байна гэсэн үг юм
- Гавилу уул ХХК, Нако түлш ХХК-иудын санхүүгийн тайлан, татварын тайлангуудыг давхар хийж байна
- Бусад тайлан мэдээнүүдийг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд хүргүүлсэн

АРАВ: БОРЛУУЛАЛТЫН АЛБА

2021 оны борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл

Хүснэгт 14

№	Худалдан авагч	Х/н	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	Нийт	Нийт	%
			тонн			Төгрөг		
1	Цахилгаан станц	тн	1,075,260	1,036,484	96%	7,849,070	47,087,620	98%
	Дархан ДЦС	тн	305,000	302,564	99%	13,572,500	13,501,788	99%
	Эрдэнэт ДЦС	тн	360,000	351,904	98%	16,020,000	15,842,957	99%
	Эрдэнэт үйлдвэр	тн	396,500	368,581	93%	17,644,250	17,130,548	97%
	Дулаан ШГ	тн	13,760	13,435	98%	612,320	597,874	98%
	Сэлэнгэ энерго	тн	-	-		-	14,454	
2	Томоохон хэрэглэгч	тн	33,997	50,044	147%	1,894,738	2,813,748	149%
	УБТЗ	тн	14,725	16,749	114%	854,050	1,001,109	117%
	Ачит ихт	тн	19,272	15,192	79%	1,040,688	815,055	78%
	Цээл буян	тн		14,753			796,674	
	Галдастай	тн		3,349			200,910	
3	Жижиглэн хэрэглэгч	тн	50,800	68,049	134%	3,009,500	4,064,736	135%
	Жижиг компаниуд	тн	31,300	46,620	149%	1,755,000	2,689,239	153%
	Шарын жижиглэн гол	тн	18,500	20,868	113%	1,202,500	1,352,482	112%
	Ажилчид	тн	1,000	561	56%	52,000	23,015	44%
4	Нийт нүүрс борлуулалт	тн	1,160,057	1,154,576	99.5%	52,753,308	53,966,104	102%

- Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 1154576 тонн 99.5%-тай, мөнгөн дүнгээр 53.63 тэрбум ₮ буюу 102% биелэлттэй. ТУЗ-ийн үнээр худалдан авалт хийдэг харилцагчдийн борлуулалтын төлөвлөгөө 149%, жижиг хэрэглэгчид 135%-р давуулан биелсэн байна.
- “Шарын гол” ХК-ийн анхны экспортыг 8 сараас эхэлж 18000 тонн экспортод нүүрс гаргасан. Тогтмол экспортод нүүрс гаргах байсан боловч БНХАУ-д ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Эрээний боомтоор задгай вагоноор нүүрс хүлээж авахыг хориглосноос дахиж нүүрс гараагүй.

Хүснэгт 15

ЖИНГИЙН ЗӨРҮҮ

Станц он	Дархан ДЦС-тай үүссэн жингийн зөрүү				Эрдэнэт ДЦС-тай үүссэн жингийн зөрүү				Эрдэнэт Үйлдвэртэй-тай үүссэн жингийн зөрүү				НИЙТ			
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1 сар	(470.1)	(157.2)	(8.3)	(442.8)	(363.7)	(331.9)	(113.5)	(10.7)	0.0	880.3	604.7	64.4	(833.8)	391.2	483.0	(389.2)
2 сар	(443.3)	(328.8)	(784.7)	(461.7)	(1,203.0)	(219.3)	(686.1)	(87.5)	(348.0)	540.9	(700.1)	(7.4)	(1,994.3)	(7.2)	(2,170.8)	(556.7)
3 сар	(831.1)	(372.0)	(93.6)	(372.1)	(953.3)	(274.3)	(385.7)	(63.7)	(1,245.8)	(181.8)	150.0	52.5	(3,030.2)	(828.0)	(329.3)	(383.3)
4 сар	(586.9)	(302.2)	(102.4)	(214.4)	(315.1)	(235.0)	(223.9)	(126.1)	(148.7)	(188.6)	729.0	(12.8)	(1,050.7)	(725.7)	402.7	(353.3)
5 сар	(401.2)	(56.8)	(140.4)	(197.7)	(104.6)	(290.1)	(196.5)	(49.9)	(106.4)	(134.7)	699.0	77.9	(612.2)	(481.6)	362.1	(169.8)
6 сар	21.9	(29.8)	(125.0)	(103.5)	(41.0)	(164.2)	0.0	(29.4)	138.8	(15.6)	417.6	120.3	119.7	(209.6)	292.6	(12.6)
7 сар	(86.9)	(19.7)	(18.9)	(111.3)	(66.9)	(48.4)	0.0	0.0	163.7	194.9	1,513.9	0.0	9.8	126.7	1,495.0	(111.3)
8 сар	(360.1)	(95.0)	(295.2)	(221.4)	(51.9)	(102.0)	0.0	(85.8)	95.3	72.8	86.3	124.5	(316.7)	(124.2)	(208.9)	(182.8)
9 сар	(645.0)	(72.0)	(466.3)	(368.8)	(219.4)	(131.9)	0.0	(231.3)	251.8	146.9	437.9	147.2	(612.7)	(57.0)	(28.4)	(453.0)
10 сар	(983.1)	(30.5)	(493.7)	(388.3)	(235.9)	(55.1)	0.0	(228.3)	50.4	230.4	272.2	113.2	(1,168.6)	144.8	(221.5)	(503.4)
11 сар	(69.2)	(35.6)	(183.8)	(320.1)	(247.4)	(233.2)	142.3	(163.5)	396.6	1,452.8	306.6	94.1	79.9	1,183.9	265.1	(389.4)
12 сар	(66.5)	(253.4)	(278.8)	(346.7)	(290.4)	(136.0)	112.8	(117.1)	684.2	1,310.4	227.5	(101.1)	327.3	920.9	61.6	(564.8)
нийт	(4,921.7)	(1,752.9)	(2,991.1)	(3,548.8)	(4,092.5)	(2,221.5)	(1,350.5)	(1,193.4)	(68.2)	4,308.7	4,744.8	672.7	(9,082.4)	334.2	403.2	(4,069.5)
Тооцсон жин	(2,460.9)	(876.5)	(1,495.6)	(1,774.4)	(2,046.3)	(1,110.8)	(675.2)	(596.7)	(34.1)	2,154.4	2,372.4	336.3	(4,541.2)	167.1	201.6	(2,034.7)

График 19



ИЛЧЛЭГИЙН ЗӨРҮҮНИЙ ОРЛОГО .мян ₮

Хүснэгт 16


- Илчлэгийн зөрүүнээс 949 сая ₮-н нэмэлт орлого орсон.

Сар	ДДЦС	ЭДЦС	ГОК 3700+-200
1 сар	34,302.43	165,264.69	330,481.41
2 сар		1,355.48	329,592.42
3 сар		55,601.13	34,135.04
4 сар		36,409.76	
5 сар		38,432.08	34,505.30
6 сар	-5,680.15	(37,463.44)	
7 сар		-	-
8 сар	9,077.16	(20,213.93)	
9 сар		11,974.51	
10 сар		96,845.65	
11 сар		(99,122.97)	
12 сар		(65,869.64)	
Дүн	37,699.44	183,213.32	728,714.17

КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

- 2021 оны бүс нутаг дахь 33-д эзлэх хувь хэмжээ 79%, 2017 онтой харьцуулахад 9 хувиар нэмэгдсэн.

График 20





СОШИАЛ СУРТАЛЧИЛГАА

“Шарын гол” ХК-ийн фэйсбүүк хуудас үүсгэж, зорилтод 9467 хэрэглэгч дагагчтай болгож компанийн мэдээ мэдээлэл, зар сурталчилгааг тогтмол явуулж байна. Нүүрсний борлуулалтын үе эхэлсэнтэй холбоотойгоор 9-р сараас эхлэн компанийн фэйсбүүкээр 25 удаагийн сурталчилгаа мэдээлэл оруулсан.

Зардал: 0₮

ХИЙГДСЭН ТОМООХОН АЖЛУУД

Хүснэгт 17

Ажлын төлөвлөгөө	Хугацаа	Ажлын гүйцэтгэл
Шарын гол ХК-н түүхэн дэх анхны экспортыг амжилттай хийсэн	7-11 сар	18000 тн нүүрс экспортод гаргасан. 11 сард хэл хааснаас хойш зогссон байна.
УБТЗ-н ажилчдын хэрэгцээний нүүрсний тендер	9-р сард	Татварын өртэй, Хамгийн бага үнээс 50 сая ₮ илүү үнийн саналтай байсан ч тендерийн материалаараа шалгарч тендер авсан нүүрсийг нийлүүлж байна.
Нүүрсний үнийн судалгаа хийж ТУЗ-р үнэ өөрчлөлт оруулсан	10-р сард	11-р сараас эхэлж үнэ өөрчлөлт оруулсан.
Улаанбаатар хотын төвийн шугамд холбогдоогүй 24-н зуух галладаг компанид нүүрс нийлүүлж байна.	9-р сард	ТУЗ-н үнээр худалдан авдаг томоохон харилцагч нэмэгдсэн.
Харилцагчийн мэндчилгээ	12-р сард	Жагсаалт гаргаж, барааны сонголтыг хийж, мэндчилгээг тарааж эхэлсэн.



АРВАН НЭГ: ХУДАЛДАА ХАНГАМЖИЙН ХЭЛТЭС

Хэлтсийн дотоод ажлууд:

- Тосны агуулахын хяналтыг сайжруулах ажлын хүрээнд камержуулах ажил хийгдсэн.
- Хангамжийн хашааны хяналтыг сайжруулах ажлын хүрээнд гэрэлтүүлэг нэмж тавигдсан, камержуулалтын тоог нэмсэн.

Агуулахын үйл ажиллагаа:

Хүснэгт 18

№	Агуулах	Утга
1	Хангамжийн агуулах	Тайлант хугацааны туршид /2021.01.01-2021.12.31/ 155,909 нэгж, 11,495,532,438 төгрөгийн үнэ бүхий бараа материалын орлого ирж, 147,214 нэгж, 10,570,464,338 төгрөгийн үнэ бүхий бараа материалын олголт хийгдсэн.
2	Тосны агуулах	Тайлант хугацааны туршид /2021.01.01-2021.12.31/ 159,397 нэгж, 1,447,583,208 төгрөгийн үнэ бүхий тос, тослогооны материалын орлого ирж, 139,842.5 нэгж, 1,308,594,110 төгрөгийн үнэ бүхий тос, тосолгооны материалын олголт хийгдсэн.
3	Тэсрэх материалын агуулах	4 удаагийн татан авалт буюу 461,901,385 төгрөгийн худалдан авалт хийгдсэн.
4	Камаз цистерн, 18-03 ДАХ	2021.01.01-2021.12.31 хугацаанд Шарын голын уурхайн үйлдвэрлэлийн талбай, карьерт нийт 47,040 км замыг туулж, 8,041,056,426.45 төгрөгийн дүн бүхий 4,375,773 литр дизель түлшийг зэхэлтээр олгосон.
5	Камаз бортовой, 56-57 ДАХ	2021.01.01-2021.12.31 хугацаанд ачаа тээврийн камаз нийт 99 удаагийн явалтаар хот хоорондын тээвэр хийж, нийт 17,159,250,496 төгрөгийн үнэ бүхий 316,904,334 нэгж бараа бүтээгдэхүүн, сэлбэг, материалыг тээвэрлэсэн.
6	Бусад байдлаа тээвэр/трейлер/	Тайлант хугацаанд нийт 8 удаагийн тээвэрлэлтийн ажил гүйцэтгүүлсэн.

Худалдан авалтын гүйцэтгэл: /Захиалсан тоо хэмжээ, хувиар/

Хүснэгт 19

Сар	Төсөвлөгдсөн		Төсөвлөгдөөгүй		Биелэлт Хувь
	Захиалгын хуудас	Нэр төрөл	Захиалгын хуудас	Нэр төрөл	
1 сар	26	104	55	332	83%
2 сар	24	260	45	340	82%
3 сар	20	150	27	211	80%
4 сар	9	87	20	133	80%

5 сар	14	152	19	169	81%
6 сар	14	179	28	107	80%
7 сар			22	217	82%
8 сар			24	412	79%
9 сар			33	428	71.3%
10 сар		1033	33	184	22%
11 сар	14	277	24	104	85%
12 сар	10	875	23	130	73%

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- Бохир түлш хадгалалтын орчныг өөрчилж, хураалтын байдлыг цэгцэлсэн.
- Хангамжийн агуулахын залгаа РУ-1 диспетчерийн байр, цахилгааны шугамын суваг руу ус ордог хэсгийг хааж, блокоор хаалт барьсан.
- Тосны агуулахад их цэвэрлэгээний ажлыг хийж, МЗХ-г хуучин сэлбэгүүдийг хүлээлгэн өгсөн.
- Ковид-19 цар тахлын цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан компаний үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажил үүргийн болоод ээлжийн хуваарилалтыг зохион байгуулалт хийж ажилласан.
- Дуудлага худалдаа зохион байгуулж актлагдсан техникүүдийг худалдан борлуулсан.
- Шатахуун Түгээх Станцыг СОБУ петро ХХК-с хүлээн авах ажлыг удирдан зохион байгуулсан.
- Ковид-19 цар тахлын цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан хүндрэлүүдтэй холбоотой тос болон сэлбэгийн 3 сарын нөөц үүсгэх ажлыг эхлүүлэн татан авалт хийгдэж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан хийгдээгүй ажлууд, шалтгаан нөхцөл:

- Тосны агуулахын байршил өөрчлөгдсөнөөр тосны агуулах дотоод засвар ,хаалга цонх засварын ажил цуцлагдсан.
- Зэхэлтийн машины худалдан авалт хийгдээгүй.

Ажилтнуудын талаарх мэдээлэл

- Худалдаа Хангамжийн Хэлтсийн хэмжээнд дарга-1, менежер-3, оффисын жолооч-1, нярав-2, түгээгч-жолооч-4, камазын жолооч-1, ачигч-1, гэсэн нийт 13 хүний орон тоотой ажилласан.



АРВАН ХОЁР: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

❖ Хагас жилийн төлөвлөсөн ажлын тоо: 31

❖ Биелсэн ажлын тоо: 28

❖ Гүйцэтгэл: / Хувиар / 90%

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

- “Шарын гол” ХК нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 417 ажилтан ажилласан ба бүтэц орон тооны хангалт 95% байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлт сонгон шалгаруулалтын чиглэлээр:

- Захиргаа хүний нөөцийн хэлтэс нь 2021 оны Компанийн бүтэц орон тоог батлуулахаар Гүйцэтгэх захиралд танилцуулсан. Механик засварын хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналтын хэлтсийн бүтэц орон тоог батлуулан мөрдөж байна.
- Эдийн засаг хөрөнгө оруулалтын мэргэжилтэнтэй хамтран бүтэц орон тооны дагуу цалингийн жишиг, албан тушаалын жагсаалтыг батлуулсан.
- Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор ажиллах хүчинг бүтэц орон тооны дагуу төлөвлөн ажиллаж байна.
- Ковидын нөхцөл байдлын улмаас зайнаас ажиллах, уурхайд байрлан 14*14 хоногийн системээр ажиллах үеийн хүний нөөцийн бүрдүүлэлт, судалгаа, ковидын мэдээ мэдээллийг тогтмол гарган хяналт тавьж удирдлагуудад танилцуулан ажилласан ба зайнаас ажиллах үеийн хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг онлайн ярилцлагын аргаар тогтмол хийж бүрдүүлэлтийг хийсэн.
- Хэлтэс хэсгийн орон тооны хэрэгцээт захиалгын дагуу бүрдүүлэлт сонгон шалгаруулалтыг тогтмол хийсэн ба нийт 68 ажилтан сонгон шалгаруулж авсан.

Хүний нөөцийн хөдөлмөрийн харилцааны чиглэлээр:

- Бүтэц орон тооны шинэчлэлтэй холбоотойгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Ажлын байрны тодорхойлолт боловсруулах сургалтыг хүний нөөцийн хэсгээс зохион байгуулахаар төлөвлөж байна.
- Цалингийн сүлжээ шинэчлэн батлуулсантай холбогдуулан ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан ба Нууц хадгалах гэрээг Захиргаа хүний нөөцийн хэлтсийн ажилтнууд болон Гүйцэтгэх захирлын туслах нартай тус тус байгуулсан.
- Ажилтнуудын ажил үүрэг хавсран гүйцэтгэх тушаал болон бүртгэлийг тогтмол хийж байна.
- Хөдөлмөрийн харилцаатай холбоотой тушаалын төслүүдийн загварыг боловсруулан хуульчид хянуулан ашиглаж байна.
- Нийт ажиллах хүчний мэдээллийг Diamond ERP болон Excel программ дээр тогтмол шинэчилэлт хийн ажиллаж байна.
- Эдийн засаг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран Компанийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлгээний KPI-н системийг 2021 оны 06 сарын 15-ний өдрөөс мөрдөн сар бүр хэрэгжүүлэн ажиллаж эхлээд байна.



- Хөдөлмөрийн харилцаанд ашиглагддаг маягтуудыг шинчилэн үйл ажиллагаанд ашиглаж байна.
- Компанийн хүний нөөцтэй холбоотой өдөр тутмын мэдээ мэдээлэл, судалгаа шинжилгээний ажил тогтмол хийгдэж ажилласан.
- Компанийн нийт ажилтнуудын судалгаа мэдээллийг тогтмол боловсруулж шинэчилж байна.

2021 онд гарсан дүрэм, журам:

- 2021 оны 01 сарын 06-ны А/01-“Хог хаягдал, хадгалах, тээвэрлэх, устгах журам”
- 2021 оны 01 сарын 22-ны А/13-“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, журам батлах тухай”
- 2021 оны 04 сарын 09-ний А/43-“ Цар тахлын халдварын үед мөрдөх, үйл ажиллагаа, зохион байгуулалтын түр журам батлах тухай”
- 2021 оны 05 сарын 05-ны А/49-“Баримт бичиг боловсруулалт, хяналт бүртгэлийн журам шинэчлэн батлах тухай”
- 2021 оны 06 сарын 08-ны А/62-“Баарсан цэнэг устгах горим батлуулах тухай”
- 2021 оны 06 сарын 22-ны А/72-“Дуудлага худалдаа зохион байгуулах журам”
- 2021 оны 06 сарын 24-ны А/76-“Шарын гол ХК-ийн Нэгжүүдийн КРІ-үзүүлэлтийг батлах тухай”
- 2021 оны 06 сарын 24-ны А/77-“Цалин хөлсний журам батлах тухай”
- 2021 оны 06 сарын 24-ны А/78-“Ажилтны цагийн бүртгэл, түүнд хяналт тавих журам”
- 2021 оны 06 сарын 24-ны А/80-“Комисс шинчилэн томилох, журамд өөрчлөлт оруулах тухай”
- 2021 оны 11 сарын 01-ний А/118 “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналтын хэлтсийн нэг бүрийн хувцас хамгаалах хэрэгсэл нийлүүлэлт, олгох хяналтын тухай”
- 2021 оны 12 сарын 21-ний А/137 “Машин техник татах, босгох үед ажиллах”
- 2021 оны 12 сарын 21-ний А/138 “Өргөх механизмын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны хяналтын тухай”

Хүний нөөцийн дотоод процесс сайжруулалтын талаар:

- Хүний нөөцийн өдөр тутмын ажил үүрэгтэй холбоотой дотоодод хэрэглэгдэх баримт бичгүүд /цалинтай чөлөө, цалингүй чөлөө, шилжүүлэн томилох хуудас гэх мэт/ шинэчлэгдэн гарсан.
- Ажилтнуудын хувийн мэдээллийг бүрдүүлэн авах зорилгоор шинэ анкетын мэдээлэл, программын бүртгэлжүүлэлт хийгдсэн.

Хүний нөөцийн үдирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

- Хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлийг боловсруулсан. Хэлтсийн зорилго, зорилтыг шинэчлэн боловсруулж байна.
- Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран 2021 оны хамтын гэрээний тодотгол хийгдэж байна.
- Ажилчдыг идэвхжүүлэх зорилгоор спортын арга хэмжээ, урлагийн наадам, шинэ жилийн арга хэмжээг тус тус Захиргаа хүний нөөцийн хэлтэс зохион байгуулсан.

Зураг 11



- Захиргаа хүний нөөцийн хэлтсээс инженер техникийн ажилтнууд болон, удирдлагын бүрэлдэхүүнд менежментийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Зураг 12



Ажилчдын шагнал урамшуулал:

2021 онд нийт 90 ажилтанг шагнал урамшуулсан. Үүнд:


- Алтан гадас одон-4 ажилтан
- Хөдөлмөрийн хүндэт медаль-12 ажилтан
- Уул уурхайн тэргүүний уурхайчин-6 ажилтан
- Уул уурхайн яамны жуух бичгээр-6 ажилтан
- Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан-1 ажилтан
- Байгал орчны тэргүүний ажилтан-1 ажилтан
- Барилга хот байгуулалтын тэргүүний ажилтан-2 ажилтан
- Боловсролын тэргүүний ажилтан-1 ажилтан
- Эрчим хүч геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүний мастер-2 ажилтан

- Компанийн оны шилдэг ажилтан-10 ажилтан
- Дархан-Уул аймгийн Найрамдлын Дархан тэмдэг-3 ажилтан
- Дархан-Уул аймгийн Тэргүүний ажилтан-6 ажилтан
- Дархан-Уул аймгийн Засаг даргын жуух бичиг-10 ажилтан
- Шарын гол сумын Хүндэт тэмдэг-2 ажилтан
- Шарын гол сумын Засаг даргын жуух бичиг-10 ажилтан
- Шарын гол сумын хүндэт өргөмжлөл-16 ажилтан тус тус шагнагдсан.

Тушаал шийдвэртэй холбоотой:

- 2021 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт А тушаал 140, Б тушаал 478 тус тус батлагдан гарсан ба Үүнд:

График 21



Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- Хийж гүйцэтгэсэн ажлууд: Катеринг гэрээт ДАЗЛ ХХК, болон Сум орон нутагтай хийсэн гэрээ контрактын дагуу тус байгууллагуудтай холбоотой ажил үүрэгт хамтран оролцон удирдлагаар ханган ажилласан.
- 2021 оны 02 дугаар сард бүтэц орон тоо шинэчлэгдсэнтэй холбоотойгоор зоогийн газрын болон цэвэрлэгээ үйлчилгээний ажилтнуудыг гэрээт компани руу 18 ажилтныг шилжүүлэн бусад ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг цуцлан цомхтгон ажилласан.
- Ковид-19 цар тахлын үед ажилтнуудын халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор хариуцлагатай жижүүр томилох, Шарын гол суманд ковидын халдвар гарах үеийн тандалт судалгаа шинжилгээг тогтмол хийж хяналт тавин ажилласан.
- Катеринг үйлчилгээг гэрээт компани хийж гүйцэтгэж байгаатай холбогдуулан тэдгээрт хяналт тавих, шаардлага хүргүүлэх ажлууд хийгдэж байна.
- Уурхайчдын баяр шинэ жилийг угтан талархлын самбар аялуулсан.
- **Төлөвлөгөөнд тусгагдсан хийгдээгүй ажлууд, шалтгаан нөхцөл:**

- Төлөвлөгөөнд тусгагдсан цогц менежменттэй *байгууллагын соёл, онцгой чадавхийн менежмент* зэрэг ажлууд нь ковидийн нөхцөл байдлаас хамаараад хойшлон хийгдээгүй дараагийн төлөвлөгөөт ажилд тусгагдсан.
- Ковид 19-цар тахлын онцгой нөхцөлөөс шалтгаалан ажилтнуудад мотиваци өгөх, хамт олны хамтач хүчийг бататгах олон нийтийн арга хэмжээ явагдаагүй.
- Шинэчлэгдэн батлагдсан хөдөлмөрийн тухай хуультай холбогдуулан Ажлын байрны тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажил хойшлогдсон батлуулах

Албан хэрэг хөтлөлтийн талаар:

- 2021 онд нийт явсан бичиг 656, ирсэн бичиг 332, томилолт-147 тус тус гарч албан бичиг, ирсэн явсан бичгийн бүртгэл тогтмол хийгдэж хугацаа хоцорсон албан бичиг гараагүй. Цаашид ирсэн явсан бичиг болон бусад компанийн мэдээллийг цахимжуулах ажил тогтмол хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Зураг 13



IT-инженер, цаг бүртгэлийн ажлын хүрээнд

“Гайхам” gps чиглэлээр:

- 2021 оны 1 сараас эхлэн Гайхам ХХК-ийн GPS болон GSM системүүд update хийгдэн уурхайн бүх техникийн мэдээлэл болон тохиргоо өөрчлөлт орсон. Тухай үед IT инженерүүдтэй холбогдон 61 төрлийн техник тус бүр update –ийг нэг бүрчлэн программ уншуулж хэвийн ажиллагаанд орсон. 3 хүний томилолт ирэх зардал 840,000₮ хэмнэсэн.
- 18 техникийг засвар үйлчилгээтэй тохиолдолд эрхийг нь түр хаалгаж зардал хэмнэсэн. /нэг техник сарын төлбөр 28,600₮

Цаг бүртгэл хяналтын чиглэлээр:

- 2021 онд Covid-21 өвчлөл тахал гарсантай холбогдуулан шинээр хурууны хээгээр нэвтрэх нь эрсдэлтэй гэж үзсэн тул SilkBio101 TC маркийн нүүр болон хурууны хээгээр цаг бүртгэгч төхөөрөмж худалдан авсан. Тухайн маркийн 2 ширхэг төхөөрөмж дээр 425



ажилтны нүүр болон хурууны хээг шинээр кодолж программ таниулах ажлыг хийж дуусгасан. Нүүр болон хурууны хээгээр цаг бүртгэгч төхөөрөмж авснаар ажилчдын цаг ашиглалт үнэн зөв гардаг болсон.

- Жилийн турш сар болгон ажилчдын ажилласан графикийг цаг бүртгэлийн программтай тулган цагийн балансыг үнэн зөв гаргасан.

Цахим үнэмлэх ид дугаар чиглэлээр:

- Brand book загварын дагуу 425 ширхэг ажлын үнэмлэх бэлдэц бэлдэж зориулалтын принтер дээр хэвлэж ажилчдад тараасан.
- 425 ажилтан тус бүрт үнэмлэх дээр QR code бүхий мэдээллийг давхар үүсгэсэн.
- Энэхүү үнэмлэх нь цаашид цахим хоолны систем, хаалганы электрон цоож зэрэгт ашиглагдан хөгжих боломжтой карт болно.
- Мөн загварын дагуу үнэмлэхний зүүлт оосрыг 2 төрлөөр, оффисын өрөөнүүдийн хаалганы хаягыг Хангамжийн хэлтэстэй холбогдон захиалга өгсөн.
- Шинээр ажилд орсон ажилчин бүрийн цээж зурагыг авч үнэмлэхийг хэвлэж өгсөн. Мөн ажлаас гарсан ажилчдын ажлын үнэмлэхийг хурааж авсан.

Радио станц чиглэлээр:

- Дахин дамжуулах төхөөрөмжийг тест хийж 1,8км зайнд шинээр байршуулсан. Ингэснээр уурхайн карьер болон зүүн жигүүр хооронд асуудалгүй болсон.
- Станцын бүртгэл, хуудас шинээр бий болгож бүх станцуудыг станц нэг бүрээр акт үүсгэсэн. Мөн шинээр олгох станц бүрийг санхүүгийн бүртгэлээс гадна бүртгэж эзэнтэй болгосон.
- Станцны антен, скейкер товчлуур гэх мэт засварыг өөрсдөө сольж, засварлах боломжгүй станцуудыг хурдан шуурхай явуулж засварлуулж байгаа. Станцын судалгааг гаргаж нэгтгэл тус тус хийгдсэн.

Хяналтын камер чиглэлээр:

- Уурхайн хяналтын 20 камер дээр нэмэлтээр 22 ширхэг камер буюу шинээр 16ш, 6ш засварлаж тус тус суулгасан.
- МЗХ-5ш, ГУШХ-2ш, НААХ-2ш, УНХ-4ш, Хангамж-3ш камерийг шинээр байршуулж нэмэлтээр сүлжээ татаж холболт хийж ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Хуучин 1 бичигч ашиглаж байсныг 2 ш болгож камерний бичлэг хугацаа 2 дахин буюу 1сар хадгалдаг болсон.

Программ хангамж чиглэлээр:

- ЦАЙНЫ ГАЗРЫН ПРОГРАММ ХАНГАМЖ - Цайны газрын программ хангамжийг 2021 оны 7 сараар эхлэн ажиллуулж эхэлсэн. Ковидээс шалтгаалаад нэмэлт засвар үйлчилгээнүүд хийгдсэн. 12 сар гэхэд хүлээлгэж сүүлийн байдлаар өгнө. Программ дээр ямар нэгэн асуудал гарвал давхар камер шүүх боломжтой. Ажилчдын нэгдсэн бүртгэлтэй болсноор хоолны талоны тооцоо үнэн зөв бодит гарна.
- E-MAIL ҮЙЛЧИЛГЭЭ - 2021 оны 8 сараас уг үйлчилгээг авч хуучин ажилчдын мэйлийг сервер дээр болон ажилчдын компьютерт хуулж, шинээр 86 ажилтанд бүртгэл үүсгэсэн.

Шинэ үйлчилгээг ажилчдын компьютер болон гар утсанд суулгаж ашиглах зааврыг танилцуулсан. Одоогоор 90 и-мэйл ашиглах ёстойгоос 86 хэрэглэгч 5 групп ашиглаж байна.

- **ФАЙЛ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ** - Ажилчдын компьютер дээрх компанид хэрэгтэй файлыг устгах, алга болохоос хамгаалж файл хадгалах серверийг ажиллуулсан. Компьютертэй бүх хэрэглэгчийг тус сервер холбосон. Мөн хэсэг нэгжүүдийг шаардлагатай файлуудаа өөрсдийн хэсгийн фолдерт хадгалж хуулах зааварчилгаа өгсөн.

Дотуур холбооны үйлчилгээний чиглэлээр :

- Уг системийг нэвтрүүлснээр уурхай өрөө болон объект хооронд холбоо барихад асуудалгүй болно. Мөн гаднаас ирэх дуудлагад автомат хариулагчаар дамжуулан хариу өгөх, дотуур ажилтан ширээний дотуур дугаараа өгснөөр гаднаас шууд холбогдох боломжтой. Төхөөрөмжийн хувьд цаашид өргөтгөх бүрэн боломжтой ба ямар нэгэн бусад төхөөрөмж авалгүй зөвхөн IP утасны тоог нэмэх байдлаар 300 хүртэл дотуур утас холбох боломжтой, 30 зэрэг яриа явагдах боломжтой болсон.
- 75050066 үүрэн холбооны дугаар шинээр авч холболт хийж нэр бүхий ажилчид дотуур холбооны утсаар ярих боломжтой болсон.

Өдөр тутмын ажил чиглэлээр :

- Компьютерын засвар үйлчилгээ, программ хангамжийн алдаа засварлах дотоод сүлжээ татах, принтер засвар /85 удаа/
- Цалингийн хавтгай мэйлээр явуулах ажлын хүрээнд мэйл хаяг үүсгэж утсан дээр суулгах /49 удаа /
- Мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрэн ТТХэлтэс, ЗХНХэлтсийн ажилчдын дунд файл солилцох хадгалах бааз үүсгэсэн.
- Компанийн webmail.sharyngol.mn maillist ажилтан бүртгэх, хасах, шинээр үүсгэх /20удаа /
- Компьютер, принтер, Сканер болон бусад тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж танилцуулсан.
- Өрөөний хаяг, үүдний хаяг захиалгыг явуулж байршуулсан.
- Станцийн судалгаа гаргаж танилцуулсан. /Нарийвчлан бүртгэх, Засварлах, актлах хариуцах эзэнтэй болгох болгосон/
- Захиргааны өрөөнүүдийн сүлжээний утаснуудыг эмх цэгцлэх ажлыг эхлүүлж шаардлагагүй өрөөнүүдийн утсуудыг авч цэвэрлэсэн.
- Өдөр бүр хэсэг хэлтсийн ажилласан цагийг тогтмол авч хэвших ажилд орсон.
- Сар болгоны сүүлд болон дундуур нийт ажилчдын ажилласан графикийг цаг бүртгэлийн программтай тулгаж цагийн баланс гаргаж ажилласан.
- Шинээр ажилд орсон ажилтнуудад ажлын үнэмлэхийг хэвлэж өгөх, цаг бүртгэлийн программ бүртгэж нүүр болох хурууг таниулсан.
- Уурхай дахь сүлжээний өргөтгөлийн ажлуудыг болох, МЗХ, Сургалт, Тосны Өрөө, ДАЗЛ, Буудалд тус тус холболтыг хийж дуусгасан.



- Интернетийн хурдыг хэвийн болгохын тулд шаардлагатай хэмжилтүүдийг хийж, холбогдох байгууллагатай холбогдон хурдыг нэмүүлэх ажлыг танилцуулсан.
- Мобикомтой хамтран ажиллах хүрээнд Харуулын төв постноос Хуучин уулын байшинруу 1,8км шилэн кабелийг үнэгүй татаж карьерт 3G, 4Gсүлжээтэй болгосон. Мөн ГУШХ давхар шилэн кабелийн нэмэлт шугамыг үнэгүй холболт хийлгэсэн.



АРВАН ГУРАВ: СУРГАЛТЫН ТӨВ

Төлөвлөгөөт ажлууд

- Тайлант хугацаанд ХАБЭА-н, хувь хүний хөгжлийн, мэргэжил чадамж эзэмшүүлэх, мэргэшүүлэх, чадавхижуулах, туршлага судлах, ур чадварын уралдаан тэмцээн гэсэн чиглэлүүдээр сургалт, хөгжүүлэлтийн ажлыг 91 удаа зохион байгуулахад 182,310,000 төгрөг зарцуулан, 1028 ажилтанг хамруулахаар төлөвлөсөн. Ковид 19 цар тахлын халдварын тархалтаас шалтгаалж, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон болон хязгаарласан нь сургалт, хөгжлийн ажилд сөрөг нөлөө үзүүлсэн хэдий ч тайлант хугацаанд бид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
- Нийт 149 удаагийн сургалтыг зохион байгуулж, 2344 ажилтанг хамруулсан.
- Нэн шаардлагатай 8 удаагийн сургалт, үнэлгээг мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтарч зохион байгуулахад 35,522,150 төгрөг зарцуулсан.
- 102.5 сая төгрөг төсөв бүхий 26 сургалтыг түр хугацаагаар хойшлуулаад байгаа ба сургалтын хэрэгцээг шинэчлэн тодорхойлж, дахин төлөвлөлт хийх шаардлагатай байгаа.

Төлөвлөгөөт бус ажлууд

- 56 удаагийн сургалтыг дотоод нөөц бололцоогоо ашиглан зохион байгуулж, 776 ажилтанг хамруулан 22,000,000 төгрөгийн зардлыг хэмнэсэн.
- Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд багтан ажиллаж, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлийн сургалт сурталчилгааг тогтмол явуулж, мэдээ мэдээллийг шуурхай дамжуулж байсан.
- Сургалт, судалгаа, шалгалтыг цахимжуулсан.
- Зөөлөн ур чадварын сургалтыг 7 хоног тутам явуулж хэвшүүлэн, нийт 13 удаагийн зохион байгуулж, давхардсан тоогоор 215 ИТА-г хамруулсан.
- Хувь хүний хөгжлийн сургагч багшийн сургалтад 2 ажилтанг хамруулж, дотоод сургалт явуулж байгаа.
- Байгууллагын процессын зураглалыг боловсруулж, хөгжүүлэх зорилгоор Хөгжүүлэлтийн багтай хамтарч ажилласан.
- ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны стандарт болох ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх ажилд оролцож байна.

Онцлох ажлууд:

- Хүний нөөцийн дутмагшлыг арилгаж, операторуудын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ХММ-ын операторуудын хөрвөх чадварын сургалт явуулсан. Сургалтад УНХ-ийн 17 операторыг хамруулсан.
- Төмөр замын хэсгийн 12 ажилтныг байгууллагын зардлаар чадамж эзэмшүүлэх сургалтад хамруулсан.
- МЗХ-ийн засварчдыг чадамжийн үнэлгээнд хамруулж, онолын мэдлэг, ур чадварын түвшинг тогтоож, цаашдын сургалтын хэрэгцээг тодорхойлсон.



- Зөвлөх инженерийн сургалтад уул уурхайн цахилгаан, механикийн чиглэлээр 3 ажилтанг хамруулсан. Мэргэшсэн инженерийн сургалтад 1 ажилтан хамрагдсан.
- Тулгамдаж буй асуудлууд:
- Байгууллагын хүний нөөцийг сургаж хөгжүүлэх бодлогыг боловсруулан батлуулж, сургалтын төвийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон, хэрэгжүүлж ажиллах
- ИТА болон мэргэжлийн өндөр зэрэгтэй ажилтнуудыг сургах зүйн сургалтад хамруулж, дотоод сургагч нарыг бэлтгэж, цагаар багшлуулах
- Сургалтын орчинг сайжруулах /сургалтын төвийн дотоод тохижилтыг сайжруулах, сургалтад ашиглагдах техник хэрэгслийг тусгайлан гаргаж өгөх/



АРВАН ДӨРӨВ: АЖ АХУЙН ХЭСЭГ

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд гарсан үр дүн:

Жилийн төлөвлөгөөний дагуу хийх ажлыг цаг хугацаанд нь сар тус бүрээр төлөвлөн гүйцэтгэлийг хийж дуусгасан.

Хүснэгт 20

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хийгдэх ажлын хамрах хүрээ	Гүйцэтгэл
1	ААбайрны бохирын хоолой солих	1 сар	100ф хоолой 30м	100%
2	Үйлдвэрийн бохир болон цэвэр усны худагт орох шат хийх	1 сар	Нийт 8 худагт 3м	95%
3	Эрэгтэй халуун усанд засвар хийх	1 сар	24м2 талбайд засвар хийсэн	100%
4	НААХ-н нарядны өрөөг засах	2 сар	18м2 өрөөний засвар хийсэн	100%
5	Лабораторийн өрөөний шугам солих	2 сар	Муудаж хага үүссэн регистер тус бүрийг шинээр сольж дуусгасан.	100%
6	Тосны складны регистер солих	2 сар	100ф 4м 3 ширхэг	100%
7	Шаазгайтын ордын шон тайрах бэлдэх	2 сар	Нийт 3м урттай 750ширхэг шон бэлдсэн	100%
8	Дулааны тоолуурын байр засварлах	2 сар	2/2 хэмжээтэй байр засварлаж дуусгасан.	90%
9	Хүний нөөцийн өрөөний засвар.	3 сар	64м2 өрөөний хана , тааз, цонх, шал зэрэг иж бүрэн засвар хийсэн	95%
10	Түлшний лабораторит засвар хийх	3 сар	18м2 өрөөний иж бүрэн засвар хийж дууссан.	100%
11	Түлшний лабораторит цэвэр ус бохирын шугам татах	3 сар	8м урт 80ф хоолойгоор бохир 20ф шугамаар цэвэр ус татаж дууссан	100%
12	Захиргааны 4 давхрын цонх шиллэх	3 сар	20.4м2 6 ширхэг цонх шиллэж дуусгасан.	100%
13	Цайны газрын жигнүүрийн өрөөний засвар	3 сар	9м2 өрөө засварлаж дууссан	100%
14	Шаазгайт ордын хашаа барих	4 сар	Нийт 2000 м торон хашаа барьж дуусгасан	70%
15	Үйлдвэрийн талбайд мод тарих хашаа барих	5 сар	Нийт 400м торон хашаа барьж дууссан	100%

16	16-р байрны гадна хашаа барих	5 сар	Нийт 160м торон хашаа барьж дуусгасан.	100%
17	Авто баазын 1200м ² төмөр дээвэр буулгах.	5 сар	Эвдэрсэн дээврийг ялгаж буулгасан	80%
18	Вагон пүүний дээвэр хийх	6 сар	20м ² төмөр дээвэр хийж дуусгасан.	100%
19	Захиргааны үүдний дээвэр хийх	6 сар	55м ² төмөр дээвэр хийж дуусгасан.	100%
20	Цайны газрын тоног төхөөрөмж байрлуулах	6 сар	Шинээр ирсэн тоног төхөөрөмжийг холболт хийсэн	100%
21	Цайны газрын хоол олголтын хана нураах ажил	6 сар	6м ² хана нурааж төмөр тулгуур хийж бэхэж дууссан.	100%
22	Авто зогсоол зөөх	6 сар	Цайны газрын 13ш зогсоол байрлуулж дууссан	100%
23	Ажилчдын амрах байрны хуучин буудлын засвар	7сард	480мкв буюу 12 өрөө тасалгааны иж бүрэн засвар хийсэн	100%
24	Үйлдвэрийн талбайн шугам хоолойны засвар	7сард	Үйлдвэрийн талбайн шугам хоолойны засвар	100%
25	Үйлдвэрийн талбайн бохирын худаг лайдах, цэвэрлэх	7сард	Үйлдвэрийн талбайн нийт 28н бохирын худаг лайдаж, цэвэрлэсэн	100%
26	Ажилчдын амрах байрны шинэ буудлын засвар	8сард	420мкв буюу 8 өрөө байрны иж бүрэн засвар мөн 120мкв үүдний пистулын засвар хийсэн	100%
27	Захиргааны үүдний хэсгийн засвар	8 сард	Захиргааны үүдний хэсгийн засвар	100%
28	Үйлдвэрийн талбайн объектын дулаан халаалт авах	9сард	Үйлдвэрийн талбайн 8 объектын дулаан халаалт авсан	100%
29	Ажилчдын амрах байрны гадна хашаа барих	9сард	Ажилчдын амрах байрны гадна хашаа барьж дуусгасан	100%
30	Захиргааны төв оффисын үүдэн хэсгийн засвар	9сард	Захиргааны төв оффисын үүдэн хэсгийн 180мкв талбайд засвар хийсэн	100%
31	Захиргааны байрнаас шалган нэвтрүүлэхийн пост хүртэлх явган замыг зигзаг хавтангаар хийх	9 сард	Захиргааны байрнаас шалган нэвтрүүлэхийн пост хүртэлх явган замыг нийт 80м зигзаг хавтангаар, 25м цутгалтаар хийсэн	100%
32	Явган замын арын хэсэгт хар хөрсөөр хучиж тэгшлэх ажил хийгдсэн.	9 сард	Явган замын арын хэсэгт 280мкв талбайг хар хөрсөөр хучиж тэгшлэх ажил хийгдсэн.	100%

33	16-р байрны №2 ба №7 тоот өрөөнд обой наах, шал шахах	10 сард	16-р байрны №2 ба №7 тоот нийт 180мкв өрөөнд обой наах, 43мкв паркетан шал шахах	100%
34	Төв оффисын алдрын танхимын засварын ажил	10 сард	Төв оффисын алдрын танхимын засварын ажлыг төлөвлөсөн хугацаандаа хийж дуусгасан	100%
35	16-р байрны бохирын шугам солих	10 сард	16-р байрны бохирын 12м шугам сольсон	100%
36	Цайны газар болон захиргааны хоорондох хүйтэн усны шугам солих	10 сард	Цайны газар болон захиргааны хоорондох хүйтэн усны шугамыг бүрэн сольсон	100%
37	Захиргаа болон цайны газрын хоорондох талбайн ажил	10 сард	Захиргаа болон цайны газрын хоорондох 600мкв зигзаг хавтангаар шахсан	100%
38	Үйлдвэрийн талбайн барилга байгууламж хэвийн халаах, сангийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	10 сард	Үйлдвэрийн талбайн барилга байгууламжийн халаалтыг хэвийн явуулж, сангийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шалгаж ажилласан	100%
39	Хэрэгцээний халуун ус усан халаагч цэвэрлэгээ үйлчилгээ хийж хэвийн ажиллагаанд бэлдэх	10 сард	Хэрэгцээний халуун ус усан халаагч цэвэрлэгээ үйлчилгээ хийж хэвийн ажиллагаанд бэлдсэн.	100%
40	Вагон пүүний шугам татах	11 сард	Вагон пүү рүү 35м шугам татсан	100%
41	Хаягдал тосны цэгийн тавцан цутгалт, дээвэрт хашилт хамгаалалт хийх ажил 50мкв	11 сард	Хаягдал тосны цэгийн 50мкв тавцанг цутгаж, дээвэрт хашилт хамгаалалт хийсэн	100%
42	Баазын блокийн цонх шиллэх	11 сард	Баазын блокийн цонх нийт 35 ширхэг 72мкв цонх шиллэсэн.	100%
43	Фитнесс заалны паарны регистер шинээр тавих	11 сард	Фитнесс заалны паарны регистерийг шинээр сольж тавьсан	100%
44	Гүний ус шүүрүүлэх хэсгийн байр халаах, зуух байрлуулах, байрны өрлөг өрөх	11 сард	Гүний ус шүүрүүлэх хэсгийн объектыг халаах зориулалтын нам даралтын зуухыг сонгосон газарт байрлуулж, гадна байрны өрлөгийг өрсөн	100%
45	16-р байрны №2, №3 тоот өрөөний засвар	11 сард	16-р байрны №2, №3 тоот өрөөний засварын ажлыг хийсэн.	100%

46	Баазийн блокийн дээврийн төмөр болон модыг хангамжийн хашаа руу зөөх	11 сард	Баазийн блокийн дээврийн төмөр болон модыг хангамжийн хашаа руу ачааны камазаар 3 удаагийн рейс хийж зөөвөрлөсөн.	100%
47	Үйлдвэрийн талбайн золбин нохой устгал хийлгэх	11 сард	Үйлдвэрийн талбай доторх золбин нохдыг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нохой устгалын хүнийг хөлслүүлэн 23 нохой устгасан.	100%
48	Үйлдвэрийн талбайн барилга байгууламж хэвийн халаах, сангийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	12 сард	Үйлдвэрийн талбайн барилга байгууламж хэвийн халаалтыг хангаж, сангийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажилласан	100%
49	Шинэ жилийн баярын бэлтгэл ажил, заал чимэглэх	12 сард	Шинэ жил, уурхайчдын баярын үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж, заалыг чимэглэж бэлтгэсэн.	100%
50	Үйлдвэрийн талбайн объектын халаалт дулааны хэвийн ажиллагааг хангах	12 сард	Үйлдвэрийн талбайн 8 объектын халаалт дулааны хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	100%
51	Захиргааны механик засварын ИТА өрөө засвар	12 сард	Захиргааны механик засварын ИТА өрөө засвар	100%

Төлөвлөгөөнөөс гадуурх хийгдсэн ажлууд гарсан үр дүн:

- Манай хэсгийн ажлын онцлог төлөвлөгөөнөөс гадуурх ажлууд өдөр тутам гардаг жишээ нь: Сан техник, мужаан, туслах ажилтан нарт төлөвлөгдөөгүй барилгын хаалга, цонх, хана, тааз, сангийн шугам, бохирын шугам засвар гэх мэт. Үүнийг тухай бүрт нь гарсан зөрчил, гэмтэл эвдрэл тус бүрийг засаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэдэг.



АРВАН ТАВ: КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон ажиллаж, компанийн ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлон шийдвэр гаргах, үйл ажиллагааг нь хянах зэргээр бүрэн эрхийнхээ хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ. Үүнд:

НЭГ. КОМПАНИЙН 2021 ОНЫ ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны хурлаар хэлэлцэх үндсэн асуудлын төлөвлөгөө
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны мэдээлэл, үйл явдлын хуанли
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод /аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо/-ын 2021 оны ажлын төлөвлөгөө
- ✓ Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хийх ажил цаг хугацааны график
- ✓ Компанийн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв зэрэг болно.

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалын зарчмуудыг баримтлан жил бүр төлөвлөгөө хийж түүнийг мөрдлөг болгон ажилласаар ирлээ.

ХОЁР. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Мэдээ мэдээлэл нь тухайн тайлант хугацааны бүхий л үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх үндсэн зарчмын илэрхийлэл юм. Тайлант хугацаанд ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан:

- ✓ Компанийн хууль, дүрэм болон бусад засаглалтай холбогдсон үйл ажиллагааны журмууд.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын тов, хуралд хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хууль дүрмийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз болон бусад мэдээлэх хэрэгслээр, хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулахаар мэдээлж байлаа.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл ажлын графикийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг уг хуралд мэдээлсэн.
- ✓ Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зорилгоор компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид, компанийн жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн аудитлагдсан тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалын тайлан зэргийг танилцуулж байлаа.



- ✓ Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээллийг зохих журмаар мэдээлж байв.
- ✓ Мөн тайлант жилд ажилласан эрх бүхий албан тушаалтнуудын талаарх зураг бүхий мэдээлэл.
- ✓ Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлж тэдний санал зөвлөмжийг нь шийдвэрт тусган түүнийг хэрэгжүүлж байдаг юм.

ГУРАВ. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-КОМПАНИЙН ХУВЬЦАА

Компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид

Нийт хувьцаа 10,170,242

Д/Д	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1.	SHG HOLDINGS 3	2,011,744	19.7
2.	SHG HOLDINGS 2	2,028,906	19.94
3.	NIHAN HOLDINGS	1,598,889	15.72
4.	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1,158,520	11.39
5.	SHG HOLDINGS 1	1,142,674	11.23
6.	MOGUL RESOURCES	1,000,000	9.83
	ДҮН	8,942,333	87.8

Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг дээрх хүснэгтээр үзүүлэв.



ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Тус компани нь компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ийн дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг. Хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 13 цагаас zoom апп ашиглан хуралдсан.

Энэхүү хуралд:

- ✓ Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл.
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
- ✓ Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Энэхүү хурал 88.75 хувийн ирцтэй байв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг товхимол болгон хэвлэж хуулийн хугацаанд брокер, диллерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, хурлын шийдвэрийн талаарх мэдээллийг компанийн болон МХБ-ийн цахим хуудаст байршуулж, уг хурлын материалыг хууль, журмын хугацаанд СЗХ, МХБ-д хүргүүлээ.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 9-р сарын 30-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах тухай болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолуудыг батлан гаргасан.

ЗУРГАА. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэйгээр ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд төлөвлөсөн болон цаг хугацааны асуудлаар хэлэлцэх асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж байлаа. Хуралд гишүүдийг бүрэн оролцуулахын тулд, зарим гишүүдийн орон зайгаас шалтгаалан зарим хурлыг онлайн хэлбэрээр хуралдаж байв.

2021 онд ТУЗ-ийн хурлын 20 тогтоол гаргасан. Үүнд:

- Аудитын компани сонгон, гэрээ байгуулах
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тухай
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурал хуралдуулах тухай
- Харилцах данс нээлгэх тухай



-

- Төсөв шинэчлэн батлах тухай
- Үндсэн хөрөнгө худалдан авах тухай
- Нүүрсний үнийн тухай
- Компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх болон томилох тухай
- 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт гаргах тухай зэрэг тогтоолуудыг тус тус гаргасан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд багтаж ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

2021 ОНД АЖИЛЛАСАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Г.Хулан
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Б.Батбаатар
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Т.Говьдэлгэр
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Н.Батнайрамдал
ТУЗ-ийн гишүүн/ердийн/



Б.Тулга
ТУЗ-ийн гишүүн /хараат бус/



Б.Итгэл
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Х.Уянга
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



О.Цэндсүрэн
ТУЗ-ийн гишүүн /хараат бус



Ж.Эрдэнэбат
ТУЗ-ийн гишүүн /ердийн/

**2021 ОНД АЖИЛЛАСАН КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ**



Х.Уянга
Гүйцэтгэх захирал



С.Ганбат
Үйлдвэрлэл
эрхэлсэн тэргүүн
дэд захирал



Л.Эрдэнэжаргал
Ерөнхий нягтлан
бодогч

2021 ОНЫ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН /ХУРААНГУЙ/



Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2022.02.28

№ 7-22/19

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН УДИРДЛАГАД

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Шарын гол” ХК (“Компани” гэх)-ийн 2021 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-38 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг:

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх нүүрсний агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан.

ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн ур чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн.

Мөн бид бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн төстэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

Нөхөн сэргээлтийн нөөц:

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшнийг үнэлсэн.

Ажилчдын тэтгэврийн сангийн нөөц:

Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцоололтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг үл үндэслэлтэй гэж үнэлсэн.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтланд бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох "Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



"Пантер Мидланд Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт ХӨРӨНГӨ	1/1/2021	12/31/2021
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,383,689,132.94	3,484,362,024.83
Дансны авлага	3,860,167,394.95	6,725,169,094.72
Бусад авлага	43,905,093.60	998,382,354.30
Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
Бараа материал	4,524,142,661.01	3,324,817,335.36
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,832,228,175.80	3,204,677,466.33
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,644,132,458.30	17,737,408,275.54
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	45,778,765,605.36	39,569,547,783.17
Биет бус хөрөнгө	17,504,472.71	522,329.46
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,340,814,369.50	1,407,680,889.50
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,017,334,566.50	2,540,050,970.89
Хойшлогдсон татварын хөрөнгө	313,786,677.18	313,786,677.18
Бусад эргэлтийн бус хөрөнгө	18,713,865,831.00	18,246,257,141.32
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	68,182,071,522.25	62,077,845,791.52
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	82,826,203,980.55	79,815,254,067.06
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	6,268,481,250.18	8,408,436,225.53
Цалингийн өглөг	294,743,229.00	287,463,725.00
Татварын өр	6,234,426,658.46	6,230,027,481.26
НДШ-ийн өглөг	275,960,412.00	139,864,693.00
Богино хугацаат зээл	16,852,971,601.16	12,313,440,128.30
Хүүгийн өглөг	1,070,222,320.46	571,023,150.23
Ногдол ашгийн өглөг	376,142.95	376,142.95
Урьдчилж орсон орлого	61,388,963.33	804,501,580.02
Нөөц/өр төлбөр/	37,959,700.60	42,619,945.00
Бусад богино хугацаат өр төлбөр	4,262,172,113.56	3,578,689,615.97
Богино хугацаат өр төлбөрийн дүн	35,358,702,391.70	32,376,442,687.26
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	0.00	0.00
Нөөц/өр төлбөр/	16,910,128,897.70	16,369,781,897.70
Хойшлогдсон татварын өр	93,311,410.26	93,311,410.26
Бусад урт хугацаат өр төлбөр	10,933,883,951.26	6,963,258,452.43
Урт хугацаат өр төлбөрийн дүн	27,937,324,259.22	23,426,351,760.39
Өр төлбөрийн нийт дүн	63,296,026,650.92	55,802,794,447.65
Эздийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	1,017,024,200.00	1,017,024,200.00
Нэмж төлөгдсөн капитал	23,145,157,851.13	23,145,157,851.13
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,906,027,807.97	16,744,190,196.39
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(21,538,032,529.47)	(16,893,912,628.11)
Эздийн өмчийн дүн	19,530,177,329.63	24,012,459,619.41
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	82,826,203,980.55	79,815,254,067.06

9-38 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1/1/2021	12/31/2021
Борлуулалтын орлого (цэвэр)	63,869,937,321.71	64,277,300,474.65
Борлуулалтын өртөг	58,581,666,890.99	55,864,147,468.74
Нийт ашиг (алдагдал)	5,288,270,430.72	8,413,153,005.91
Түрээсийн орлого	26,951,091.91	1,237,580,453.78
Хүүний орлого	9,470,236.41	1,777,455.23
Ногдол ашгийн орлого	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	2,410,197,429.04	258,835,941.45
Борлуулалт маркетингийн зардал	275,384,537.32	272,539,473.54
Ерөнхий ба удирдлагын зардал	2,092,370,764.68	1,703,677,158.64
Санхүүгийн зардал	1,779,823,876.66	1,653,739,478.83
Бусад зардал	4,626,601,317.09	1,680,874,175.39
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(648,330,449.93)	658,897,146.41
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(71,615,511.96)	(201,990,548.81)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,616,006,245.64)	5,057,423,167.57
Орлогын татварын зардал	239,048,767.80	575,140,877.79
Татварын дараах ашиг (алдагдал)	(1,855,055,013.44)	4,482,282,289.78
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,855,055,013.44)	4,482,282,289.78
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	(1,855,055,013.44)	4,482,282,289.78
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

9-38 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн (төгрөгөөр)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	63,041,213,200.95	63,783,996,490.04
Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого	62,593,161,663.75	63,260,133,984.94
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,062,708.79	9,766,965.60
Бусад мөнгөн орлого	445,988,828.41	514,095,539.50
Мөнгөн зарлагын дүн (-)	51,435,483,937.57	52,357,220,146.32
Ажилчдад төлсөн	7,727,063,362.30	6,772,515,700.22
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,130,022,318.00	1,824,182,199.00
Бараа материал худалдан авахад төлсөн	1,563,353,576.00	2,930,045,952.81
Ашиглалтын зардалд төлсөн	54,682.00	192,018,328.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,598,770,589.84	19,609,511,512.39
Хүүний төлбөрт төлсөн	821,282,769.20	1,548,680,148.36
Татварын байгууллагад төлсөн	2,633,449,988.97	4,358,142,586.47
Даатгалын төлбөрт төлсөн	132,709,433.07	95,806,593.85
Бусад мөнгөн зарлага	14,828,777,218.19	15,026,317,125.22
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,605,729,263.38	11,426,776,343.72
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	63,622,815.23
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		61,845,360.00
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
Хүлээн авсан хүүний орлого	0.00	1,777,455.23
Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,365,255,632.00	2,608,541,956.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,365,255,632.00	2,608,541,956.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,365,255,632.00)	(2,544,919,140.77)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	351,846.60	3,800,003,516.38
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	3,800,000,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	0.00
Төрөл бүрийн хандив	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн ашиг	351,846.60	3,516.38
Мөнгөн зарлагын дүн (-)	7,144,357,686.01	12,581,187,827.44
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,567,961,783.66	8,914,711,015.60
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,506,817,842.61	3,594,345,989.09
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн алдагдал	69,578,059.74	72,130,822.75
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(7,144,005,839.41)	(8,781,184,311.06)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,096,467,791.97	100,672,891.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	287,221,340.97	3,383,689,132.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,383,689,132.94	3,484,362,024.83

9-38 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	17,284,563,312.80	(20,061,513,020.86)	21,385,232,343.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	17,284,563,312.80	(20,061,513,020.86)	15,338,358,299.15
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(1,855,055,013.44)	(1,855,055,013.44)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	(378,535,504.83)	378,535,504.83	0.00
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	16,906,027,807.97	(21,538,032,529.47)	19,530,177,329.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	1,017,024,200.00	0.00	0.00	(21,538,032,529.47)	(20,521,008,329.47)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	4,482,282,289.78	4,482,282,289.78
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	16,906,027,807.97	(17,055,750,239.69)	24,012,459,619.41

9-38 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

“Шарын гол” ХК-ийн 2021 оны жилийн санхүүгийн тайлангаар богино хугацаат 32.7 тэрбум төгрөгийн өр, нийт 55.8 тэрбум төгрөгийн өртэй гарсан бөгөөд цаашид өр төлбөрөө барагдуулах, үйл ажиллагаанд хөрөнгө оруулах шаардлагатай тул Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2021 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Мэндсайхан/-д даалгасугай.

ДАРГА



Г.ХУЛАН